# Монгол улсын боловсролын салбар дахь Мэдээлэл харилцаа холбооны технологийн бодлогын тойм шинжилгээ

## Агуулга


Товчилсон үгийн жагсаалт

Танилцуулга

Боловсрол дахь МХХТ-ийн бодлогын орчин

1. МХХТ-ийн дэд бүтэц

2. Сургуулийн өмнөх боловсролын салбар дахь МХХТ

3. Бага, дунд боловсролын салбар дахь МХХТ

4. Мэргэжлийн боловсрол, сургалтын салбар дахь МХХТ

5. Дээд боловсролын салбар дахь МХХТ/Багш нарт зориулсан МХХТ

6. Насан туршийн боловсролын салбар дахь МХХТ

7. Сургалтын хөтөлбөр, агуулга, суралцагчийн үнэлгээн дэх МХХТ

8. Боловсролын салбарын мэдээллийн систем

9. Боловсролын салбарын МХХТ-ийн санхүүжилт

10. Боловсролын салбарын МХХТ-ийн засаглал

Дүгнэлт, санал зөвлөмжүүд

Эх үүсвэрүүд

Хавсралтууд

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| БМДИ | Багшийн мэргэжил дээшлүүлэх институт |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БСМС | Боловсролын салбарын мэдээллийн систем |
| БСХДХТ | Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө |
| БТОУХ | Боловсролын төлөвлөлтийн олон улсын хүрээлэн |
| БУМС | Боловсролын удирдлагын мэдээллийн систем |
| БХ | Боловсролын хүрээлэн |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ДБУМС | Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| МБС | Мэргэжлийн боловсрол, сургалт |
| МУБИС | Монгол Улсын Боловсролын Их Сургууль |
| МБС-УМС | МБС-ын Удирдлагын мэдээллийн систем |
| МХХТ | Мэдээлэл харилцаа холбооны технологи |
| НТБТ | Насан туршийн боловсролын төв |
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| ОУЦХБ | Олон улсын цахилгаан холбооны байгууллага |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| ЮНЕСКО | НҮБ-ийн Боловсрол, Шинжлэх ухаан, Соелын байгууллага |

# Танилцуулга

“Бодлого”-ыг өргөн утгаар нийгмийн бүлэг хүмүүс, бизнесийн байгууллага, Засгийн газар, түүнчлэн улс төрийн нам тодорхой нөхцөл байдалд юу хийхээ албан ёсоор хүлээн зөвшөөрсөн цогц үзэл санаа, төлөвлөгөө гэж тодорхойлдог (Кембрижийн толь бичиг).

Засгийн газрын түвшинд бодлогыг “Засгийн газар болоон бусад байгууллагуудаас гаргасан хууль, дүрэм, журам, захиргааны арга хэмжээ, урамшуулал болон сайн дурын үйл ажиллагаа” гэж үздэг. Түүнчлэн бодлогын шийдвэр нөөцийн хуваарилалтад байнга тусгагддаг.” [1] Тиймээс "боловсролын бодлогод боловсролын системийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомжууд хамаарна."[2]

Бодлогын тойм шинжилгээг гол төлөв а) бодлого хэрэгцээ шаардлагатай, нийцтэй хэвээр байгаа эсэх; б) тухайн бодлогыг өөр бодлоготой уялдуулах, өөрчлөх шаардлагатай байгаа эсэх, в) одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, бусад бодлоготой нийцэж байгаа эсэх, г) бодлогын үр нөлөө, тодорхой байдлыг сайжруулах өөрчлөлт оруулах шаардлага бий эсэх зэргийг тодорхойлоход чиглүүлдэг. [3] Өөрөөр хэлбэл бодлогын тойм шинжилгээ нь хэрэгжүүлж буй бодлого өнөө үед хамааралтай хэвээр байна уу, хүлээж байгаа үр дүнд хүрэхэд үзүүлж буй нөлөө хэвээр байна уу гэдгийг нягтлахад оршдог.

---

[1] *https://www.cdc.gov/policy/analysis/process/definition.html*
[2] *https://courses.lumenlearning.com/boundless-politicalscience/chapter/education-policy/*
[3] *https://www.ucop.edu/ethics-compliance-audit-services/policy/policy-development/update-policy.html*

Дэлхий дахинд өрнөж байгаа хоёр үйл явдал олон улс оронд бодлогын тойм шинжилгээ хийхэд хүргэлээ. Нэгдүгээрт аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал, хоёрдугаарт КОВИД-19 цар тахал юм. Эдгээр үйл явдлууд бидний амьдрах, суралцах, ажиллах, бие биетэйгээ харилцах харилцааг шууд утгаар нь өөрчилж байна.

Бодлого олон төрөл байдаг ч тэдгээрийг реактив ба проактив гэсэн үндсэн хоёр бүлэгт ангилж үздэг. “Реактив бодлого нь тодорхой асуудал, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээтэй холбогдож,  одоо байгаа бэрхшээлийг арилгахад чиглэгддэг. Тиймээс асуудлыг яаралтай шийдвэрлэх үүднээс  реактив бодлого боловсруулах явц нь хурдан байдаг.” Харин “проактив бодлого нь санаа зовнил, асуудал, онцгой нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэхэд зориулагддаг” (Chehab, 2017). Реактив бодлого нь богино хугацааны шийдэл байх хандлагатай байдаг бол проактив бодлого нь урт хугацааны төлөвлөлтөд суурилдаг.

Бодлогын үр өгөөжийг дүгнэх цорын ганц арга бол хэрэгжилт, үр дүн, үр нөлөө бүрийг шинжлэх явдал юм. Зарим тохиолдолд бодлого ба үр дүн хоёрын хоорондох уялдаа холбоо илт байдаг. Бусад тохиолдолд, ялангуяа бодлогын хэрэгжилтэд муу хяналт тавьсан тохиолдолд бодлого ба үр нөлөөний холбоог тодорхойлоход хэцүү байдаг.

Энэхүү бодлогын тойм шинжилгээ нь Монгол улсын боловсролын салбар дахь МХХТ (Мэдээлэл Харилцаа Холбооны Технологи) -ийн талаарх бүхий л асуудлыг  нэг барим бичигт оруулахыг зорьсон болно. Одоогийн байдлаар Монгол улсын боловсролын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаан дахь МХХТ-ийн асуудал нь хэд хэдэн баримт бичигт болон хэрэгжүүлэх институцид тархан байрласан байна. Боловсрол дахь МХХТ-ийн бодлогын тойм шинжилгээний зорилго нь боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөг боловсруулах Засгийн газрын төлөвлөгөөг харгалзан үзэж баримт болон зөвлөмжийг боловсруулахад оршино. Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) нь боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөг боловсруулах үйл явцыг удирдах ажлын хэсгийг аль хэдийн томилжээ.[4]

---

[4] *2021 оны 3-р сарын 15-ны өдрийн А/84 тоот сайдын тушаал*

Боловсролын салбарын МХХТ-ийн мастер төлөвлөгөөний агуулгыг урьдчилан тооцоолж, энэхүү бодлогын тойм шинжилгээг 10 чиглэлээр хийж байгаа болно. Мөн энэ баримт бичигт тусгагдсан санал, зөвлөмжүүд Монгол улсын боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөг боловсруулах үйл явцын эхлэл болно гэж найдаж байна.

# Боловсролын салбар дахь МХХТ-ийн бодлогын орчин

МХХТ-ийн асуудал Монгол улсын боловсролын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, зорилтуудын хэд хэдэн эх сурвалжид тусгагджээ. Эдгээр эх сурвалжуудад тусгасан МХХТ-той холбоотой гол заалтуудын товч тайлбарыг дор үзүүлэв.

1. **Боловсролын тухай хууль -** Боловсролын тухай хууль (2002), Бага, дунд боловсролын тухай хууль (2002), Дээд боловсролын тухай хууль (2002), Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008), Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2009), Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль (2018)-иудад МХХТ-ийн талаарх заалтууд маш хязгаарлагдмал байгааг олж үзэж болно. Цаашид МХХТ-ийг тусгахын тулд эдгээр хуулиудын заримд, эсвэл тусгагдаагүй бол дийлэнхэд нь нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны тогтоолоор (2020 оны 8-р сарын 26) цахим орчинд сурах, онлайнаар сурах эрх зүйн орчныг бүх шатны боловсролд бүрдүүлэх зорилгоор боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэх үүргийг засгийн газрын холбогдох байгууллагуудад чиглэл болгосон байна.

2. **Монгол Улсын Их Хурлын тогтоолууд -** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020, 2020-2024), Төрийн боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024), Алсын хараа 2050 баримт зэрэг бичгүүдийг тус тус баталсан.

3. **Засгийн газрын тогтоолууд -** Цахим засаглал үндэсний хөтөлбөр (2019 он), Тогтвортой хөгжлийн боловсролын үндэсний хөтөлбөр (2018-2022), Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017), Нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөр (2014 он), “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр (2013), Монгол улсын Боловсролыг 2006-2015 он

хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдэд МХХТ-ийн асуудлыг авч үзсэн. Тухайлбал, үндэсний хөтөлбөрүүд нь олон сургуулийг компьютерээр хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна. БСШУС-ын сайдын тушаалаар (2018) сургуулиудад гар утас ашиглахыг хоригложээ.

4. **Сайдын тушаалууд -** Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-г батласан. Мөн КОВИД-19 цар тахлын хөл хорионы үед цахим сургалт явуулах удирдамж, сургалтын шинэ хөтөлбөр, насан туршийн суралцахуйн удирдамж зэргийг батласан байна.

5. **Алсын хараа 2050 –** Боловсрол дахь МХХТ-той холбоотой зарим гол томъёоллууд: i) боловсролын салбарын мэдээллийн системийг бүрэн боловсронгуй болгох; бүх түвшинд нэвтрүүлэх; салбарын бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээнд ашиглах; мэдээллийн аюулгүй байдлыг хангах; ii) нээлттэй боловсролын тогтолцоог бий болгож, цахим болон зайны сургалтын нэгдсэн платформыг боловсруулж, бүх түвшний боловсролыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, бүх насны суралцагч болон иргэдэд зориулсан цахим сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулж түгээх; iii) олон улсын МХХТ-ийн сургалтын хөтөлбөр, стандартад нийцүүлэн багш нарын МХХТ-ийн ур чадвар, цахим орчинд суралцах ур чадварыг дээшлүүлэх, иргэд, олон нийт, ба сурагчдад онлайн орчинд аюулгүй байдлыг хангах чадварыг эзэмшүүлэх, сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, бүх төрлийн сургалтын байгууллагыг оролцоог хангах.

6. **Тогтвортой хөгжлийн зорилт 2030 -** зарим гол томъёоллууд: i) насан туршдаа суралцахуйн тогтолцоог бий болгох; ii) төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, олон улсын хамтын ажиллагааны сан, урт хугацааны хөнгөлөлттэй зээлийг ашиглах, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, тогтвортой хөгжлийн алсын харааг хэрэгжүүлэх бодлогуудыг уялдуулах; iii)

мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, хөдөө орон нутагт өндөр хурдны цахим сүлжээг суурилуулах, ашиглалтыг нэмэгдүүлэх, үндэсний хиймэл дагуул хөөргөх.

7. **МХХТ-ийн үндэсний бодлого** - зарим гол томъёоллууд: a) иргэдийг тоон бичиг үсгийн боловсролтой болгох; b) Монгол хүний боловсрол, мэдлэг, чадварыг мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан хөгжүүлэх;
Монгол улсын МХХТ-ийн салбарын удирдлага, шийдвэр гаргагчид тус улсыг цахим үндэстэн болгох зургаан зорилтыг тодорхойлсон байна. Эдгээр зорилтууд нь:

i) Дижитал дэд бүтэц;
ii) Цахим засаглал;
iii) Мэдээллийн аюулгүй байдал;
iv) Тоон бичиг үсгийн чадавх;
v) Инновац, үйлдвэрлэл;
vi) Үндэсний хөгжлийн хурдасгуур.

8. **Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр** - КОВИД-19 цар тахлын улмаас үүссэн нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого: i) цахим сургалтын платформ бий болгох, цахим контентуудыг боловсруулах ба бэлтгэх; ii) цахим сургалтын тохиромжтой хэлбэр, хувилбаруудыг судлах; iii) телевиз, интернет ашиглах боломжгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бүрдүүлэх; iv) цахим сургалтыг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.

9. **Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030 он)-д** бодлогын таван чиглэлийг тодорхойлсон. Үүнд: i) Насан туршийн

суралцахуй; ii) Ногоон, ухаалаг, дижитал технологи; iii) бататгах сургалт; iv) байгууллагын чадамж; v) нээлттэй, хүртээмжтэй боловсрол.

10. **Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан -** бодлого болон эрхзүйн орчин, ялгаатай сэдэв ба боловсролын түвшингүүдийн хүрээнд хэрэгжилт ба үр дүнгийн талаарх мэдээллийг боловсрол дахь МХХТ хэмээх бүлэгт агуулсан.

11. **Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ -** Боловсрол ба суралцахуйд МХХТ-ийг нэвтрүүлэх гэсэн бүлэгтэй бөгөөд МХХТ-ийн дэд бүтэцтэй холбоотой асуудлууд, боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөний хэрэгцээ, боловсролын салбарын мэдээллийн систем (ESIS), насан туршын суралцахуй ба багш нарын МХХТ-ийн чадавхыг бэхжүүлэх зэрэг асуудлыг багтаасан.

12. **Монгол улсын Мэргэжлийн боловсрол, сургалтын (МБС) бодлогын тойм шинжилгээ** - Монгол дахь дижиталчлал болон ажилгүй байгаа залуучуудын сонирхлыг татахуйц Мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжиж буй салбаруудыг тодорхойлсон.

13. **Боловсрол дахь МХХТ-ийн асуудлаарх 2015 оны Чиндаогийн Тунхаглал -** Энэ нь боловсролын салбар дахь МХХТ-ийн талаарх дэлхийн анхны Тунхаглал юм. Үүнд "*Тогтвортой хөгжлийн зорилтууд дахь тэгш боломж, хүртээмж, чанар, насан туршийн суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэхэд технологийг хэрхэн ашиглаж болох тухай*"[5] тоймлон өгүүлсэн болно. Боловсролын салбарт МХХТ-ийг хөгжүүлэхэд улс орнуудад зайлшгүй хэрэгтэй гарын авлага юм.

---

[5] *https://en.unesco.org/news/qingdao-declaration-promotes-use-ict-achieve-education-targets-new-sustainable-development*

Боловсролын бодлогын баримт бичгүүдэд МХХТ-ийг тусгасан талаарх дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү.

# 1. МХХТ-ийн дэд бүтэц

Боловсролын салбар дахь МХХТ-ийн амжилт нь тухайн улсын МХХТ-ийн экосистемээс ихээхэн хамааралтай байдаг. Тухайн улсын МХХТ-ийн дэд бүтэц нь анги танхимд ямар нөөцийг ашиглах боломжтойг тодорхойлдог (АХБ, 2009). Жишээлбэл, цахим хичээл рүү нэвтрэхэд интернет холболт хэт удаан эсвэл сурагчдын цөөн хэсэг нь МХХТ-ийн төхөөрөмжийг ашиглах боломжтой бол хичнээн сайн боловсруулсан ч цахим сургалтын систем доголдох болно.

2015 оны Чиндаогийн Тунхаглалд “2030 он гэхэд чадвар, нийгэм, эдийн засгийн байдал, газарзүйн байрлалаас үл хамааран бүх охид, хөвгүүдэд интернетэд холбогдсон дижитал төхөөрөмжүүд болон холбогдох цахим сургалтын орчинд нэвтрэх нөхцөл боломжийг бүрдүүлэх үүрэг амлалт авахыг” засгийн газруудад уриалжээ.

МХХТ-ийн дэд бүтцийн хангамж (жишээлбэл, компьютер, интернет) нь ерөнхий боловсролын сургуулиудад чухал гэж үзэж тооцогдож ирсэн бөгөөд БШУЯ нь нийт сургуулиудийн 90%-ийг хамруулж чадсан байна. Гэсэн хэдий ч томоохон бэрхшээл бол хуучин тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, мөн шинэчлэх явдал юм. Одоогийн МХХТ-ийн дэд бүтцийн тоног төхөөрөмжийн 40% нь эвдэрсэн эсвэл солих шаардлагатай гэсэн тооцоо байна. Хамгийн гол нь санхүүжилтийг хаанаас олох вэ гэдэг асуудалтай үргэлж тулгардаг байна.

### Бодлогын асуудал 1: МХХТ-ийн төхөөрөмж ашиглах боломжийг хангах

Монгол улсын Засгийн газар сургуулиудын МХХТ-ийн дэд бүтцийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж иржээ. Доор дурдаж байгаа Засгийн газрын шийдвэрүүд нь энэхүү арга хэмжээний жишээ юм.

1) Засгийн газрын 2005 оны 216 тоот тогтоолоор "Дижитал Монгол үндэсний хөтөлбөр"-ийг баталж хэрэгжүүлсэн. Үүний зорилго нь “2020 он гэхэд ерөнхий боловсролын дунд ангийн 10 сурагч тутамд 1 компьютер хуваарилан тараах” (БХ, 2019) байв.

2) Засгийн газрын 2006 онд 192 тоот тогтоолоор Боловсролын мастер төлөвлөгөөг (2006-2015) баталж, МХХТ-ийн дэд бүтцийг сайжруулах зорилтуудыг тодорхойлсон. Үүнд: сургуулиудыг интернетэд холбох; ерөнхий боловсролын сургуулийн компьютерийн хангамжийг эрс нэмэгдүүлэх; хөдөө орон нутгийн сургуулиудад МХХТ-ийг нэвтрүүлэх; сургуулиудыг цахим сургалтын тоног төхөөрөмж, компьютерээр тоноглогдсон анги танхимаар хангах зэрэг болно.

Энэхүү мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд МХХТ-ийн хэд хэдэн үндэсний санаачилгуудын хүрээнд сургуулиуд компьютер хүлээн авсан. “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөр (2008-2012)-ийн хүрээнд 21 аймаг, Улаанбаатар хотын сургуулиудад 11,813 ширхэг “ХО” компьютерийг тараажээ. “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд (2014-2016) багш нарт 25,000 зөөврийн компьютер, сургуулийн компьютерийн лабораторид 11,240 зөөврийн компьютер нэмэлтээр олгожээ (БХ, 2019).

Эдгээр хүчин чармайлтын үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн нэг компьютерт ногдох сурагчийн тооны харьцаа эрс сайжирч 2008 онд 1:31 байсан бол 2017 онд 1:12 болж нэмэгджээ. Цэцэрлэгүүдийн хувьд багш нарын компьютер ашиглах боломж бас нэмэгджээ. Компьютер/багшийн тооны харьцаа 2007 онд 1:3 байсан бол 2017 онд бараг 1:1 болж өссөн байна (БХ, 2019).

Дараа нь 2020 онд КОВИД-19 цар тахал гарч сургуулиуд хаагдаж, сурагчид гэртээ үргэлжлүүлэн суралцах шаардлага үүссэн. Сургуулиудын компьютерыг сурагчид

ашиглаж чадахгүй байдал бий болжээ. Айл бүр гэртээ компьютер, интернет холболтгүй учраас Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хичээлүүдийг телевизээр дамжуулж хүргэхээр болжээ. Гэсэн хэдий ч монголын айл өрхүүдийн ердөө 30% нь л компьютертэй байгаа бөгөөд үүнээс ч бага хувь (23%) нь гэртээ интернет холболттой байдаг байна.

Монгол улсын Засгийн газар бүх түвшний боловсролыг цахим сургалтад бүрэн шилжүүлэх урт хугацааны бодлогыг баримталж байгаа өнөө үед бүх суралцагчид гэртээ болон сургуульд байхаас үл хамааран МХХТ-ийн тоног төхөөрөмжийг ашиглах боломжийг бүрдүүлэхийн төлөө ажиллах нь зүйтэй юм.

### Зөвлөмж

Засгийн газар сургуулиудад компьютер тараах стратегиа дахин авч үзэх хэрэгтэй байж болзошгүй юм. КОВИД-19 цар тахал сүүлчийн гамшиг биш байх магадлалтай гэж үзвэл ирээдүйд ийм нөхцөл байдал үүсэх тохиолдолд Боловсрол, шинжлэх ухааны яам нөөц төлөвлөгөөтэй байх хэрэгтэй. Монгол улс цахим сургалтын сайн платформ ашиглаж болох ч бүх суралцагчид гэртээ МХХТ-ийн төхөөрөмжгүй бол харьцангуй үр дүн багатай болох юм.

Засгийн газар "Хүүхэд бүрт компьютер" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлагаа эргэн судлах боломжтой юм (2008-2012). 2014 онд хийсэн бие даасан судалгаагаар дээрх хөтөлбөр нь багш, сурагчид, эцэг эх, олон нийтэд сайнаар нөлөөлсөн болохыг харуулжээ.[6] Тухайн үед зөөврийн компьютерууд үнэтэй байсан бөгөөд таблет гэх мэт бусад МХХТ-ийн төхөөрөмжүүд хараахан нийтэд хүртээлгүй байсан тул нэг хүүхдэд нэг зөөврийн компьютер (OLPC) нь үр дүнтэй байв. Өнөөдөр Засгийн газар

---

6 *https://www.academia.edu/6688760/Multiple_Perspectives_of_the_One_Laptop_Per_Child_Initiative_the_Case_of_Mongolia*

ХО компьютер ашиглах шаардлагагүй юм, учир нь зах зээл дээр хямд үнэтэй, сонголт хийх боломжтой илүү олон МХХТ-ийн төхөөрөмжүүд байдаг болжээ.

Нийт суралцагчдыг МХХТ-оор хангах нь өндөр өртөгтэй болно. Засгийн газар МХХТ-ийн төхөөрөмж худалдан авах чадваргүй оюутнуудыг эрэмбэлэх, эсвэл гэр бүлүүдтэй зардлыг хуваах зохицуулалт хийх зэрэг төлөвлөгөөг боловсруулж болох юм.

### Бодлогын асуудал 2: МХХТ-ийн дэд бүтцийн тогтвортой байдал

МХХТ-ийн дэд бүтцийн өөр нэг асуудал бол төхөөрөмжүүдийг хадгалах, хэвийн ажиллагааг хангахад өртөг өндөр байгаа явдал юм. Ихэнх компьютерууд байнга ашиглагдаж байгаа эсэхээс үл хамааран 3-5 жилийн хугацаанд ашиглагддаг. Засвар үйлчилгээ, хэвийн ажиллагааг хангах, солих зардалд засгийн газар тогтмол хэмжээний хөрөнгө хуваарилах шаардлагатай юм.

Энэ асуудлыг Боловсролын бодлогын тойм шинжилгээнд (ЮНЕСКО, 2020) онцлон цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвүүдэд тогтвортой хэрэгжүүлэхийг онцлон, хэрэгцээнд тулгуурласан засвар үйлчилгээний төлөвлөгөө гаргахыг санал болгосон юм.

#### Зөвлөмж

Засгийн газар, ихэвчлэн сургуулиуд нь засвар үйлчилгээ/тогтвортой байдлын төлөвлөгөө төдийгүй цахим хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байдаг.[7] Засгийн газар энэ тал дээр илүү зохион байгуулалттай

[7] *For more information: What Can We Do About the Growing E-waste Problem?, https://news.climate.columbia.edu/2018/08/27/growing-e-waste-problem/*

ажилласнаар ихээхэн хэмжээний мөнгө хэмнэж, мөн байгаль орчны зардлыг бууруулах боломжтой.

Оюутнуудад МХХТ-ийн төхөөрөмжүүдийг түгээх бас нэг давуу тал бол сургуулиудад засвар үйлчилгээ шаардлагатай тоног төхөөрөмжүүд бага байх тул засвар үйлчилгээ, тогтвортой ажиллагааг хангах зардал бага гарснаар засгийн газарт төсвийн хэмнэлт бий болно. Хэмнэсэн төсвийг дараа нь МХХТ-ийн хуучин төхөөрөмжүүдийг солиход ашиглаж болно.

Бие даасан судалгаанд дурдсанаар "Хүүхэд бүрт компьютер" хөтөлбөрийн нэг давуу тал нь эцэг эхчүүд өөрсдөө зөөврийн компьютер худалдаж авах, эвдэрсэн зөөврийн компьютерыг засварлах зардалд дэмжлэг үзүүлэхэд боломжтой гэсэн явдал юм. Өөрөөр хэлбэл, гэр бүлийнхэн нь эдгээр төхөөрөмжийн гол хэрэглэгчид нь хүүхдүүд гэдгийг мэддэг тул засвар үйлчилгээ болон хэрэглээний зардлыг хуваалцахад бэлэн байгаагаа илэрхийлсэн юм.

## 2. Сургуулийн өмнөх боловсролын салбар дахь МХХТ

Өнөө үеийн хүүхдүүд ирээдүйн 21-р зууны суралцагчид гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Тэд эргэн тойрондоо МХХТ-той өссөн. Тиймээс ч 2015 оны Чиндаогийн Тунхаглалд дараах санааг оруулсан нь чухал болсон юм: “МХХТ-ийн гайхалтай дэвшил, интернет холболтын асар хурдацтай өргөжилт нь өнөөгийн ертөнцийг улам бүр харилцан уялдаатай болгож, бүх охид, хөвгүүдэд МХХТ-ийн талаарх мэдлэгийг олгож байна”.

### Бодлогын асуудал 3: Цэцэрлэгт МХХТ тохиромжтой юу?

Монгол улсын Засгийн газар цэцэрлэгт МХХТ-ийг нэвтрүүлэх талаар албан ёсны ямар байр суурьтай байгаа вэ? Боловсролын мастер төлөвлөгөөнд (2006-2015) бүх сургууль, цэцэрлэгийг интернет холболттой байхыг тусгажээ. 2017 он гэхэд Монгол улсад сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дийлэнх нь (78.7%) интернет холболттой байсан бөгөөд цэцэрлэгийн багш, компьютерийн харьцаа нь 1.2 (БХ, 2019) байжээ. Интернет, компьютерт зарцуулсан хөрөнгө оруулалтыг харгалзан үзвэл Засгийн газар МХХТ-ийг цэцэрлэгийн түвшинд нэвтрүүлэх хүчин чармайлт гаргаж байгаа нь харагдаж байна.

КОВИД-19 цар тахлын хөл хорионы дэглэмийн үед Боловсрол, шинжлэх ухааны яамнаас цэцэрлэгийн хүүхдүүдэд хамааралтай сайдын хоёр тушаал гаргажээ. Сайдын А/140 тоот тушаалаар (2020 оны 3-р сар) цэцэрлэг, сургуулиудад: хөл хорионы дэглэмийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор телевиз, онлайн, радио зэргийг ашиглан зайн сургалтыг бэлтгэх; хөл хорионы хязгаарлалтын үед зайн сургалтын хөтөлбөрийн агуулгыг эрчимжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх тухай, Сайдын А/17 тушаалаар (2020 оны 8-р сар) сургуулиудад Монголын телевизүүдийн холбоотой хамтран цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан телевизийн хичээлийг бүрэн, чанартай зохион байгуулахыг үүрэг болгов.

Цэцэрлэгийн түвшинд МХХТ-ийг хэрхэн ашиглаж байгаа болон хэрхэн ашиглахыг харуулсан бусад тайлан байхгүй байна. МХХТ-ийг бага насны суралцагчдад заах болон тэдний сонирхлыг татах зорилгоор ашиглаж байна уу? Цэцэрлэг нь цахим бичиг үсэг, мэдээллийн бичиг үсгийн боловсрол олгох хамгийн тохиромжтой насны үе шат мөн үү?

### Зөвлөмж

Цэцэрлэгийн түвшинд МХХТ-ийн боломжит хэрэглээг судлах нь зүйтэй. “Бага насны хүүхдийн боловсролд МХХТ-ийн үүрэг ба нөөц бололцоо: Шинэ Зеланд ба олон улсын бүтээлийн тойм судалгаа” баримт бичгийг судлах нь маш тохиромжтой эх сурвалж байх болно. Энэхүү баримт бичигт "МХХТ нь бага насны хүүхдүүдийн сурч боловсрох, хүрээлэн буй орчинд аль хэдийн нөлөөлсөн" болон "МХХТ нь бага насны хүүхдийн бодит чадваруудын олон талыг бэхжүүлэх шинэ боломжуудыг санал болгож байна" хэмээн дурджээ. Наад зах нь, Монгол улс хүүхдүүдэд цахим бичиг үсэг, мэдээллийн бичиг үсэг зэрэг 21-р зууны зайлшгүй шаардлагатай ур чадварыг илүү эрт олгох нь тохиромжтой юм.

## 3. Бага, дунд боловсролын салбар дахь МХХТ

МХХТ-ийг боловсролд нэвтрүүлэхэд гаргасан анхны бэрхшээлүүдийн нэг бол хүн амын нэг хэсгийг хамруулаад бусдыг орхигдуулсан явдал байв. Хотын сургуулиуд эрчим хүчтэй холбогдсон байдаг тул хөдөөгийн сургуулиудаас илүү давуу талтай байв. Ерөнхий боловсролын сургуулиудад дунд ангийн сурагчдыг компьютер ашиглахад насаар илүү, төлөвшсөн байсан тул бага ангийн сурагчдаас илүү анхаарч байв. Үүний үр дүнд МХХТ-ийн санаачилгууд тус улсын тоон мэдлэгийн ялгааг арилгах бус улам нэмэгдүүлжээ.

КОВИД цар тахлаас өмнө БШУЯ-аас цахим сургалтын платформыг хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байсан юм. Хэдийгээр платформ хэрэгжихэд бэлэн болоогүй байсан ч, цар тахлын улмаас тус ажил эрчимжсэн байна. БШУЯ нь цахим сургалтын платформыг 2021 оны 5 дугаар сар гэхэд бүрэн ажиллагаатай болгоно гэж найдаж байна. Одоогоор илүү их контент байршуулах, онлайн модулиудыг дуусгахад гол анхаарлаа чиглүүлж байна.

КОВИД цар тахлын хөл хорионы улмаас сурагчид гэрээсээ буюу зайнаас суралцах шаардлагатай болсон үед БШУЯ-аас сурагчдад телевиз, цахим сувгийг ашиглан хичээл заах шийдвэрийг гаргав. Суралцахуйн тасралтгүй байдлыг хангах үүднээс БШУЯ удирдамж, агуулгыг бэлтгэх шуурхай арга хэмжээ авсан. Багш, сурагчдын зүгээс хичээлээ үзэж хугацаанд нь дуусгахын тулд хичээл зүтгэл гаргасан ч ялгаатай үр дүнгүүд үзүүлсэн байна. “*Засгийн газрын шуурхай хариу арга хэмжээний үр дүнд Монгол дахь сурагчид сургууль хаагдсаны дараа эхэлсэн телевизийн хичээлээр үргэлжлүүлэн суралцах боломжтой болсон. Гэсэн хэдий ч НҮБ-ын Хүүхдийн сангийн судалгаанаас харахад энэхүү арга хэмжээ төлөвлөж байсан шиг үр дүнтэй хэрэгжээгүй байна. Судалгаанд хамрагдсан сурагчдын 50-иас бага хувь нь хичээлийг тогтмол үздэг байсан бөгөөд хүүхдүүдийн 20 гаруй хувь нь телевизийн хичээл огт үздэггүй байв. Сонирхолтой нь эдгээр хүүхдүүдийн 16 хувь нь шаардлагатай тоног төхөөрөмжтэй байсан ч телевизийн хичээл үздэггүй байжээ. Хичээлийн агуулга ерөнхийдөө тохиромжтой байсан хэдий ч, хичээлүүд илүү сонирхолтой, интерактив хэлбэрээр явагдсан бол чанар нь илүү байх байсан*”. (НҮБ-ын Хүүхдийн сан, 2021)

## Бодлогын асуудал 4: МХХТ нь бага, дунд сургуулийн аль алинд нь байх ёстой

2015 оны Чиндаогийн Тунхаглалд улс орнуудын Засгийн газруудыг "МХХТ-ийн анхан шатны мэдлэг чадвар, мэдээллийн боловсролыг бага, дунд сургуулийн боловсролын хөтөлбөрт оруулах шаардлагатайг хүлээн зөвшөөрөхийг" уриалсан байдаг. Тойм шинжилгээний хүрээнд авч үзсэн бараг бүх баримт бичгүүдэд бага ангийн МХХТ-ийн үйл ажиллагааны талаар бараг дурдаагүй байна. Бага ангид багш, компьютерийн харьцаа 1:6 байна гэж Монгол улсын Боловсролын суурь мэдээллийн тайланд товч дурджээ. Бага сургуулийн багш нар компьютер ашиглах нь ихэвчлэн мэргэжлийн хөгжлийн болон оффисын хэрэгцээнд зориулагдсан байдаг (БХ, 2019). БШУЯ-ны ярилцлагад дунд сургуулиудад МХХТ-ийг нэвтрүүлэх нь илүү чухлаар

тооцогдож байгаа нь батлагджээ. БШУЯ бага сургуулийн МХХТ-ийн хамрах хүрээг өргөжүүлэхийг хүсч байгаа ч санхүүжилтийн асуудлаас болоод үүнийг хийж чадахгүй байна.

КОВИД-ийн улмаас санхүүжүүлэгч байгууллагууд болон олон улсын хандивлагчдын нийгэмлэг улс орнуудад боловсрол дахь МХХТ-ийн салбарт үзүүлэх дэмжлэгээ нэмэгдүүлсэн. Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ), НҮБ-ын Хүүхдийн сан, ЮНЕСКО нь сургуулиудыг интернетэд холбох зорилго тавин хамтран ажиллажээ. "КОВИД-19 цар тахал гарснаар интернетэд холбогдох асуудал урьд өмнөхөөс илүү их тулсан чухал асуудал болсон нь тодорхой болсон. … Өнөөдөр холболтыг илүү өргөн хүртээмжтэй байлгахын тулд үндэсний дэд бүтцийг бэхжүүлэх шаардлагатай байна. Залуучуудын боловсролын хүртээмж, сургалтын үр дүн, орлогын чадавхыг дээшлүүлэх, тэдний нийгэм, эдийн засгийн хөгжлийг сайжруулахын тулд сургуулийн интернет холболтын төлөвлөгөөг дэмжих, чанартай суралцахад хөрөнгө оруулах шаардлага нь мөн адил чухал юм. Технологийн саад бэрхшээлийг арилгах, холболтын зардлыг бууруулахын тулд цахим дэд бүтэц, цахим боловсрол, ялангуяа эмзэг бүлгийн хүн амд хөрөнгө оруулах шаардлагатай байгаа тул засгийн газрууд хөгжлийн түншүүдтэйгээ илүү нягт хамтран ажиллах хэрэгтэй байна" (ОУЦХБ, ЮНЕСКО, ба НҮБ-ын Хүүхдийн сан, 2020).

### Зөвлөмж

Энэ нь БШУЯ-нд санхүүжилт олж авах, бага сургуулийн МХХТ-ийн дэд бүтцийг өргөжүүлэн хөгжүүлэх боломж юм. Засгийн газар энэхүү зорилгыг албан ёсны болгон бодлогын хүрээнд бага, дунд сургуульд МХХТ-ийг хэрэгжүүлэх шийдвэр гаргах хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэх өөр нэг арга бол Боловсролын мастер төлөвлөгөөнд эсвэл боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөнд тэргүүлэх чиглэлүүдийн нэг болгон тусгах явдал юм.

## Бодлогын асуудал 5: Сургуулиудад МХХТ-ийн соёлыг хөгжүүлэх

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (БСХДХТ)-д "*одоогийн бодлого нь сургуулийн удирдагчдыг зайлшгүй шаардлагатай чадвар болох академик манлайллыг үл харгалзан захиргааны албан тушаалд томилдог*" гэж тэмдэглэжээ. Бусад орнуудын туршлагаас харахад сургуулиудын МХХТ-ийн өндөр хөгжил, сургуулийн удирдлагуудын манлайлал хооронд харилцан уялдаа холбоо байна.

Азийн хөгжлийн банк (АХБ)-аас гаргасан Боловсрол дахь МХХТ-ийн сайн туршлагад "Сургуулийн удирдагуудын ажил мэргэжлийн хөгжилд сургуулийн технологийн манлайллыг гүйцэтгэх, арга зүйн хувирган өөрчлөлт, түүнчлэн сургуулийн МХХТ-ийн соёлыг хөгжүүлэх зэрэг ур чадварын хөгжлүүд орно. Үндсэндээ, тэднийг сургуулийн технологийн манлайлагч болгоход сургах ёстой" гэж зөвлөсөн байна. Өөрөөр хэлбэл, "сургуулийн удирдлагууд сургуульдаа МХХТ-ийн талаарх алсын харааг сурталчилж, МХХТ-ийн соёлыг төлөвшүүлэн сургуулийн бүх ажилтнуудад МХХТ-ийн байнгын хэрэглэгчид болох боломжийг олгох үүрэгтэй юм" (АХБ, 2009).

### Зөвлөмж

Сургуулийн удирдах ажилтнуудыг МХХТ-ийн манлайлалд сургаж, сургалтын жилийн хугацаанд сургуулийнхаа МХХТ-ийн төлөвлөгөө боловсруулахыг үүрэг болгох шаардлагатай. БШУЯ-аас тоног төхөөрөмж, интернет холболт болон МХХТ-ийн бусад дэмжлэгийг олгохын өмнө сургуулиудад тавигдах шаардлагуудын нэг нь тухайн сургуулийн МХХТ-ийн төлөвлөгөөтай байх ёстой юм.

Сингапур улсад Боловсролын яамнаас бүх сургуулиудыг МХХТ-ийн интеграцын хувьд ижил түвшинд байхыг шаарддаггүй. Зарим сургуулиуд бусдаас илүү дэвшилттэй байдаг. МХХТ-ийг сайн нэвтрүүлж байгаа сургуулиудад урамшуулал үзүүлэх болон шинэчлэл хийх эрх чөлөөг олгодог. Харин бусад сургуулиудыг стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхийг нь тасралтгүй хянаж байдаг.

## 4. Мэргэжлийн боловсрол, сургалтын салбар дахь МХХТ

Цахимжуулалт ба дижитал технологи нь Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС)-д дэмжлэг болж чадна. Онлайн сургалтын хөтөлбөрүүд нь залуу хүмүүсийн сонирхлыг татах анхан шатны мэдлэг, ур чадварыг олгох бүрэн боломжтой юм. Монголын МБС-д Moodle ашиглан цахим сургалт явуулахыг оролдож байсан ч төсөв, зохион байгуулалтын асуудлаас болж бүтэлгүйтсэн.

Монголын МБС-д цахим сургалтыг хөгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж, үр дүнд хүрч байна. Цаашид шинэ сургалт, шинэ хичээл нэмж, МБС-ын багш нарын чадавхыг дээшлүүлэхэд анхаарч байна. Багш нар цахим боловсролоо дээшлүүлэхийн зэрэгцээ цахим сургалтыг ашиглан хичээлээ хэрхэн үр дүнтэй заах аргазүйд суралцах хэрэгтэй.

2015 оны Чиндаогийн Тунхаглалд МБС ба насан туршийн суралцахуйн нягт уялдаа холбоог тусгасан байдаг. “Насан туршийн суралцахуй нь хувь хүний ажил, амьдралын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх удирдах зарчим юм. Сургалтыг түгээн хүргэх сувгийг боловсронгуй болгох, төрөлжүүлэх, чанарыг сайжруулж эмзэг ба дэмжлэг шаардлагатай бүлгийнхэнд үүний дотор алслагдсан хөдөө орон нутгийн хүүхэд залуучууд, насанд хүрэгчид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах боломжтой тул бид  боловсрол ба сургалтад, тэр дундааа МБС, албан болон албан бус сургалтад МХХТ-ийг ашиглахыг зөвлөж байна.

МБС-д МХХТ-ийг улам ихээр өргөн ашиглах өөр нэг шалтгаан бий. МХХТ-ийн чадавхтай боловсон хүчинтэй байх нь мэдлэгийн эдийн засаг руу шилжиж буй улс орны шинж тэмдэг юм (АХБ, 2009).

### Бодлогын асуудал 6: Залуучуудын ажилгүйдлийн түвшинг шийдвэрлэх

2019 онд боловсруулсан МБС-ын салбарын бодлогын тойм шинжилгээнд дурдсанаар Монгол улсын МБС-ын салбарт тулгарч буй хамгийн том бэрхшээл бол залуучуудын ажилгүйдэл юм. Хөдөлмөр эрхлэлт, боловсрол, сургалтад хамрагдаагүй (15-24 насны) залуучуудын эзлэх хувь 23% хэвээр байна. Ажлын ур чадвар таарахгүй байдал хөдөлмөр эрхлэхэд бэрхшээл учруулж байна. 21-р зууны зайлшгүй шаардлагатай ур чадвар болох харилцаа холбооны чадвар, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч чадвар, манлайлал зэрэг нийгмийн харилцааны чадвар, түүнчлэн МХХТ-ийн ур чадварыг ажил олгогчид хайж байна (ЮНЕСКО, 2019).

#### Зөвлөмж

Шинээр гарч ирж буй болон эрэлт ихтэй салбаруудад МБС-ын онлайн сургалтыг хөгжүүлэх хэрэгтэй. МБС-ын салбарын бодлогын тойм шинжилгээнд Монгол улсын эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлөх магадлалтай хэд хэдэн чиглэлийг тодорхойлсон бөгөөд энэ нь залуучуудад ажлын байрыг бий болгох юм. Тодорхойлогдсон салбарууд нь:

i. Аялал жуулчлал ба зочлох үйлчилгээ
ii. Өндөр технологийн хөдөө аж ахуй;
iii. Гидропоник, аквапоник, аэропоникийн шинэ технологийг ашиглан хотын аж ахуй эрхлэх;
iv. Өндөр технологийн мал аж ахуйн эрхлэлт; ба
v. FAB-LABS эсвэл 21-р зууны STEM-ийн хөнгөн нэмэлт үйлдвэрлэл.

КОВИД-оос өмнө дэлхийн аялал жуулчлалын эрэлт хэрэгцээ хурдацтай өсөн нэмэгдсэний үр дүнд Монгол улсын аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбар эрчимтэй хөгжиж байв. МБС-ын салбарын бодлогын тойм шинжилгээнд дурдсанаар

Монгол улсын аялал жуулчлалын салбар 121,000 ажлын байр бий болгосон нь нийт ажил эрхлэлтийн 10,4%-ийг эзэлж байна. Аялал жуулчлалын салбарт цахим худалдааны платформ хөгжүүлэх, илүү олон үйлчлүүлэгчдэд хүрэхийн тулд вэбсайт бүтээх МХХТ-ийн мэдлэгтэй ажилчид шаардлагатай болно. Ази, Африкт залуучууд, технологийн хослол хөдөө аж ахуйд инновац хийж байгаа олон жишээ бий. Цахим сургалтаар дамжуулан ур чадвар эзэмшүүлэх замаар алслагдсан, хөдөө орон нутгийн залуучуудыг МБС-д татан оролцуулах боломжтой юм.

## Бодлогын асуудал 7: МБС-ын багш нарын чадавхыг сайжруулах

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөнд (2021-2030) тусгаснаар МБС-ын чанарыг сайжруулах нэг арга зам бол МБС-ын багш нарыг тасралтгүй давтан сургах явдал юм. Хэрэв цахим сургалтыг ашиглан залуусыг МБС-д татан оролцуулж чадвал энэ салбарын олон жилийн асуудал болох МБС-ын мэргэжлийн багш нарын дутагдалтай байдлыг шийдвэрлэх боломжтой юм (АХБ, 2009).

Шинээр батлагдсан МБС-ын багшийн хөгжилд МБС-ын багш нарын МХХТ-ийн ур чадварыг хөгжүүлэх бодлого, стратегиудыг багтаасан. Хэлэлцүүлгээр МБС-ын багш нарын МХХТ-ийн ур чадварыг дээшлүүлэх зайлшгүй шаардлага гарч байна – тэд цахим сургалтыг ашиглан сургалт явуулах, цахим сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөрийг хэрхэн хөгжүүлэх талаар сурч боловсрох шаардлагатай байна. Засгийн газраас МБС-ын төвүүдэд цахим сургалтын орчинд шаардлагатай тоног төхөөрөмж, интернетийн найдвартай холболтоор хангаж чадвал МБС-ын багш нарын ажлыг хөнгөвчлөх болно. Хөдөө орон нутаг, алслагдсан дүүргүүдийн МБС-ын төвүүдэд МХХТ-ийн хэрэгцээ өссөөр байна.

### Зөвлөмж

МБС-ын багш нарт зориулсан хамгийн сайн чанартай сургалтыг бий болгох хэрэгтэй. Монголд сургалтын хөтөлбөр боловсруулахад заавал шинээр зохиох шаардлагагүй. Нэмж хэлэхэд, КОВИД-ийн үр дүнд МБС-д зориулсан олон тооны цахим материалуудыг ашиглах боломжтой. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас (ОУХБ) гаргасан зарим эх сурвалжуудыг дор хонцолж байна. Үүнд:

*МБС-ын багш, сургагч багш нарт зориулсан нөөц*

**1. КОВИД-19-ийн үед онлайнаар багшлахуй**
*https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/---ifp_skills/documents/genericdocument/wcms_742674.pdf*

**2. КОВИД-19-ийн үед МБС-ыг удирдах**
*https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/---ifp_skills/documents/genericdocument/wcms_742672.pdf*

**3. КОВИД-19-ийн үед онлайнаар суралцахуй**
*https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/---ifp_skills/documents/genericdocument/wcms_742673.pdf*

# 5. Дээд боловсролын салбар дахь МХХТ/Багш нарт зориулсан МХХТ

Засгийн газраас багш нарын МХХТ-ийн ур чадварыг хөгжүүлэх тал дээр байнга анхаарч дэмжсээр ирсэн. 2006-2015 оны Боловсролын мастер төлөвлөгөөний нэг зорилгод “багш нарын сургалтад МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулах” гэж тодорхойлсон байсан. Багшийн мэргэжил дээшлүүлэх тухай Сайдын А/528 (2019) тоот тушаалд “мэдээллийн технологийн боловсрол болон сургалтад багш нарын технологийг хэрэглэх чадварыг сайжруулах”, мөн “сургалтын үйл ажиллагаанд МХХТ-ийн хэрэглээний нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын материалууд болон бусад програм хангамжийн цахим мэдээллийн сангийн хэрэглээг бүрдүүлэх” талаар тусгагдсан. Сайдын А/67 (2020) тоот тушаалаар Багшийн МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлагыг баталсан. Багшийн МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлага нь багшийг сургаж хөгжүүлэх тухай дараах зургаан чиглэлтэй. Үүнд:

1. Боловсрол дахь МХХТ-ийн бодлого
2. Сургалтын хөтөлбөр ба үнэлгээ
3. Сурган заах арга зүй
4. МХХТ
5. Сургалтын зохион байгуулалт ба менежмент
6. Багшийн хөгжил.

### Бодлогын асуудал 8: Багш нарт зориулсан МХХТ-ийн цогц чадамжийн стандартыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага (ICT-CST)

Боловсролын бодлогын тойм шинжилгээнд тусгагдсан санал, зөвлөмжүүдийн нэг бол: Багшийн МХХТ-ийн цогц чадамжийн стандартыг багш бэлтгэх, багшийг ажилд

авах, гүйцэтгэлийн үнэлгээ, багшийн мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалтад системтэйгээр нэвтрүүлснээр МХХТ-ийг интеграцчилсан сурагч төвтэй суралцахуйг бий болгох, өөрийн багшлахуй болон өдөр тутмын захиргааны ажилд МХХТ-ийг хэрэглэхэд өөртөө итгэлтэй болж, урам зоригийг бий болгох гэж заажээ.

### Зөвлөмж

БШУЯ-аас холбогдох дээд боловсролын байгууллагуудаас, ялангуяа Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС)-ийн багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн тохироц, нийцийгсайжруулах чиглэл өгч багш нарт зориулсан МХХТ-ийн цогц чадамжийн стандартыг нэвтрүүлж болно.

Үүнтэй ижил ажлыг багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад бас хийх хэрэгтэй. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ) одоо байгаа сургалтын хөтөлбөр хичээлүүдийг хянан үзэж Багш нарт зориулсан МХХТ-ийн цогц чадамжийн стандарттай нийцэх шинэ хөтөлбөрийг батлах ёстой. Сургалт зохион байгуулах чадавх дутмаг, хязгаарлагдмал байгаа бол БШУЯ болон БМДИ-ээс хувийн хэвшилтэй түншлэх, эсвэл олон улсын сургалт зохион байгуулагчдыг урьж оролцуулах ёстой.

Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээнд шаардагдаж байгаа МХХТ-ийн шинэ чадамжуудыг тусгасан байх шаардлагатай боловч багш нарыг сургалтад хамрагдсаны дараа л зөвхөн хэрэгжүүлэх ёстой.

## Бодлогын асуудал 9: Багш нар МХХТ-ийн  ахисан түвшний сургалтыг олж авах хязгаарлагдмал боломжууд

МХХТ-ийг ашиглах багш нарын чадварууд өөр өөр байдаг (MIER, 2019). Ерөнхийдөө багш нар вэб хуудас ашиглах, олон нийтийн сүлжээ хэрэглэх, сургалтын материалууд бэлдэх талаар сайн мэдлэгтэй байдаг. Тэд БМДИ ба МУБИС-ийн шинэлэг санаачилгуудын үр шимийг нь хүртсэн. БМДИ багш нар бие биенээсээ суралцах боломжтой байх, мөн төрөл бүрийн сэдвээр багш нарын заах арга зүйн практик хэрглээг дэмжих портал сайтыг хөгжүүлсэн. Энэхүү портал сайт нь 26,857 хэрэглэгчидтэй бөгөөд 21,000 хуудас мэдээ мэдээллүүдтэй. Монгол Улсын Боловсролын Их Сургуулиас (МУБИС) жил бүр "Мультимедиа програм хангамжийг сургалтад хэрэглэх, хөгжүүлэх нь" багш нарын уралдааныг зохион байгуулдаг. МУБИС Зайны сургалтын төвөөр дамжуулан онлайнаар багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулдаг (ЮНЕСКО, 2019).

Гэсэн ч МХХТ-ийн багш нарын чадварыг тасралтгүйгээр сайжруулах сургалт, үйл ажиллагаанууд дутмаг байна. Багш нар дижитал талбарт бүтээлч байх, мэргэжлийн ур чадвар, багшийн мэргэжил дээшлүүлэх зэрэг хэсгүүд дээр сургалтад хамрагдах хэрэгцээтэй байгаагаа илэрхийлсэн (БХ, 2019).

Ихэнх багш нар МХХТ-ийн үндсэн сургалтад хамрагдаж байсан эсвэл нэвтрэх эрхтэй байдаг. Сургах болон суралцахуйд шаардлагатай МХХТ-ийн үндсэн ур чадваруудыг олон багш маш сайн эзэмшсэн байдаг. Гэсэн хэдий ч ахисан түвшний МХХТ-ийн сургалтуудыг хайж олоход боломжууд хязгаарлагдмал байгаа нь МХХТ-ийн багш нарын тогтвортой хөгжилд саад болж байна. 2018 онд Багш нарын бэлэн байдлын судалгаа хийгдэж үүнд ойролцоогоор 2000 орчим багш хамрагдсан байна. Дараах хүснэгтэд багш нарын МХХТ-ийн сургалтад хамрагдах хэрэгцээг харуулав.

**Багш нарын МХХТ-ийн сургалтад хамрагдах хэрэгцээ**

- Мультимедиа сургалтын материал бэлдэх

- МХХТ-ийг ашиглан сургалтын шинэ аргуудыг боловсруулах /төсөлд суурилсан сургалт, компьютер ашиглан хамтран суралцах гэх мэт/
- МХХТ-ийг сурагч оюутнуудын үнэлгээнд ашиглах
- Судалгааны тодорхой хэсгүүдэд МХХТ-ийг уялдуулах
- Заах болон сурахдаа олон нийтийн сүлжээг ашиглах
- МХХТ-ийг хичээл байдлаар заах
- МРР ашиглан шинэлэг арга зүй боловсруулах
- Цахим сэтгүүл болон бүртгэлийг баяжуулах, боловсруулах
- Онлайн сургалт ба МХХТ-ийг ашиглан онлайнаар багш, оюутнуудын сургалт явуулах
- Цахим хичээл, анимэйшн боловсруулах
- Сургалтын материалууд боловсруулах
- Компьютерийн програмууд дээр чөлөөтэй ажиллах
- Заах болон сурахад хичээлээс гадуурх үйл ажиллагаа ба нийгмийн сүлжээнд МХХТ-ийг хэрэглэх
- Боловсролын сайтуудаас мэдээлэл авах
- Ангийн мэдээллийг боловсруулахад ашиглах хялбар програмыг хэрэглэх

**Зөвлөмж**

МХХТ-ийн олон чиглэлээр сургалт явуулах боломжийг өргөжүүлэхийн тулд БШУЯ Монголд сургалт зохион байгуулах олон улсын мэргэжилтнүүдийг оролцуулсан хувийн хэвшлийг сургалт зохион байгуулахыг эсвэл онлайнаар сургалт явуулахыг дэмжих ёстой. Сургалт нь Багшийн МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлагад суурилсан хийгээд нийцтэй байх ёстой. Төсөв санхүүгийн асуудлаас хамаарч сургалтыг зөвхөн ганц хоёрхон удаа зохион байгуулж, оролцогчдын тоо хязгаарлагдвал сургагч багшийг бэлдэх хөтөлбөрөөр сургалтыг зохион байгуулах ёстой. Энэ нь сургалтад хамрагдсан хүмүүс өөрийн болон бусад сургууль, институцид сургалтаа дамжуулан сургана гэсэн үг юм.

## 6. Насан туршийн боловсролын салбар дахь МХХТ

Монгол улс дахь Насан туршийн боловсролын төв (НТБТ) нь ерөнхийдөө тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр дутмаг байдаг. Маш цөөн тооны төвүүд МХХТ-ийн төхөөрөмжүүдтэй байх ба заримд нь цахим сургалтын зэрэг үйлчилгээг санал болгох боломж байдаггүй. Ихэнх НТБТ-үүд хэвлэмэл материалыг сургалтад ашигладаг. НТБТ-үүдээс ямар төрлийн үйлчилгээг үзүүлэх, ямар байгууллага тус төвүүдийн үйл ажиллагаа, хөгжлийг удирдах ёстой талаар тодорхойлсон хууль дүрэм, бодлого гэж байдаггүй. НТБТ-үүдийн багш нарыг хөгжүүлэх, хамгаалах тал дээр маш бага зүйл хийгддэг учраас багш нар нь чадамж сул байдаг (аюулгүй байдал болон нийгмийн хамгааллын асуудлууд). Тийм ч учраас НТБТ-үүдэд багш нар дутагдалтай байдаг. Өөрөөр хэлбэл, НТБТ-үүд үүдээ барихгүйн тулд өөрсдөө л үүнийг зохицуулж ажилладаг.

КОВИД-оос шалтгаалж сургуулиуд хаагдаж, хүмүүс гэртээ байх болсноор НТБТ-үүдийн талаарх хүмүүсийн үзэл бодол өөрчлөгдсөн. Одоо үед насан туршийн боловсрол нь тогтвортой хөгжлийн боловсролын хэлэлцүүлэгт томоохон байр суурийг эзлэх болсон. БШУЯ-аас НТБТ-үүдийн чадавхыг бэхжүүлэх, шинэ бүтцийг санал болгох, чиг үүргийг тодорхойлох талаар бодлого журам, хуулийн баримт бичгүүдийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан (иргэдийн тоон бичиг үсгийн боловсролыг нэмэгдүүлэх). Иргэд одоо л НТБТ-үүдийн ач холбогдлыг ойлгож эхэлж байна.

### Бодлогын асуудал 10: Насан туршийн боловсролын төвүүдийн МХХТ-ийн нөөц, эх үүсвэрийн дутагдал

Засгийн газар “насан туршийн боловсролын төвүүдийг нөөцийн дутагдлаас болж янз бүрийн насны хүмүүс болон зорилтот бүлгийнхний сурах хэрэгцээг хангахын тулд маш хэцүү байдалд байдаг” гэдгийг сайн мэддэг. Хэдийгээр 2006-2015 оны Боловсролын мастер төлөвлөгөөнд насан туршийн боловсролын санхүүжилтийг жил

бүр 8%-иар өсгөх талаар санал оруулсан ч дээрх байдал хэвээр байгаа. Засгийн газрын бодлого болон бодит байдал хоёр нийцэхгүй зөрж байна. Нэг талаас, бодлогод дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

+ Иргэдийг тоон бичиг үсэгтэн болгох
+ Насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх
+ НТБТ-үүдийн санхүүжилтийг жил бүр 8%-иар өсгөх
+ НТБТ-үүдийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх

Нөгөө талаас, энэ салбарын бодит байдал дараах зүйлсийг илэрхийлж байна. Үүнд:

- НТБ-д зориулсан төсөв байхгүй
- Орон нутгийн удирдлагуудад төсөв хуваарилах хууль ёсны эрх байхгүй
- Ажилчдаар дутмаг
- Тоног төхөөрөмж муу
- Сургалтын материалуудаар дутмаг
- Хөгжлийн бэрхшээлтэй залуу хүмүүст хүртээмж хязгаарлагдмал
- Хөдөө орон нутаг болон алслагдсан газрын хүмүүст хүртээмж хязгаарлагдмал

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө болон Боловсролын бодлогын тойм шинжилгээнд санал болгож зөвлөмжилснөөр эдгээр асуудлуудын логик шийдэл нь Насан туршийн боловсролын төвүүд бүх суралцагчдыг эрх тэгш, тасралтгүй суралцах боломжоор хангахын тулд дэд бүтэц болон тоног төхөөрөмжүүдийг сайжруулах явдал гэсэн байдаг. Энэ л хамгийн зохистой зүйл юм. Гэсэн хэдий ч, хэрвээ Засгийн газар санхүүжилт болон тогтвортой байдлын хувьд асуудалтай хэвээр байвал ийнхүү байгаа бодит байдал (status quo) нь хэвээр үргэлжилсээр байна гэсэн үг бөгөөд ийм тохиолдолд бусад хувилбаруудыг хайх хэрэгтэй.

## Зөвлөмж

Засгийн газраас насан туршийн суралцахуйн хөтөлбөрийг санал болгож, мөн үйл ажиллагааг нь хэвийн явуулахад нь тусалж чадахгүй байгаа бол төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлүүдэд Насан туршийн боловсролын төвүүдийн ажлын зарим хэсгийг даалгаж ажиллуулах тухай асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны яам авч үзэх хэрэгтэй.

Засгийн газар төсвийн хөрөнгийг зорилтот хүмүүсийн насан туршийн боловсролд зарцуулагдаж байгаа эсэхийг баталгаажуулах ваучерийн системийг ашиглаж болно. Энэхүү ваучер нь насан туршийн боловсролын хөтөлбөрийг бүх Монголын иргэн бүрт хүргэхэд НТБТ-үүдийн үйл ажиллагаа эрхлэгчдэд туслах ёстой.

Монголын насан туршийн боловсролын шинэчлэлийг хурдан шуурхай хянан хэрэгжүүлэхийн тулд БШУЯ хиймэл оюун ухааны хэрэглээг судлах ёстой. ЮНЕСКО-оос саяхан гаргасан нийтлэлд хиймэл оюун ухааныг насан туршийн боловсролд хэрхэн үр дүнтэйгээр ашиглаж болох тухай гурван аргыг оруулсан байсан. Хиймэл оюун ухааны технологийн хэрэглээ нь 21-р зууны сургалтын орчинд хамааралтай насан туршийн боловсрол олгох асуудлыг амжилтад хүргэх арга замаар хангана.

### Боловсролын нийтлэг эрх ашгийн төлөө хиймэл оюун ухааныг хэрхэн хамгийн сайн ашиглаж болох вэ?

**1. Хиймэл оюун ухаанд суурилсан насан туршийн боловсролын хамтрагчид**

Сурагч, оюутан бүр насан туршдаа өөрийн гэсэн хувийн багштай байх хүсэл нь хиймэл оюун ухааныг суралцахуйд хэрэглэх хамгийн анхны сэдэл болсон зүйл юм. Хувь хүнийг насан туршид нь дагалдан явах хиймэл оюун ухаанд суурилсан хамтрагчийг бүтээхэд техникийн хувьд ухаалаг утас болон түүнтэй холбоотой технологиудыг хөшүүрэг болгон ашиглах нь тийм ч хэцүү биш.

**2. Хиймэл оюун ухаан тасралтгүй үнэлгээг боломжтой болгосон**

Оюутан сурагчдын ахиц дэвшлийг тогтмол хянах, тэдний чадварыг үнэлэх, мөн тохирох хариуг өгөх зорилгоор үнэлэн дүгнэх өөр аргыг хиймэл оюун ухааныг ашиглан хэрэгжүүлэх боломжтой.

**3. Хиймэл оюун ухаан насан туршийн боловсролын амжилтуудын бүртгэлийг боломжтой болгосон**

“Хиймэл оюун ухаанд суурилсан цахим баримт бичиг /портфолио/”-ийг сурагчийн албан ёсны сургалтад хамрагдсан бүхий л хугацааны туршид тэмдэглэгдсэн тасралтгүй үргэлжлэх мэдээллийн үнэлгээнүүдийг сурагчдын албан бус сургалт (хөгжим болон гар урлал сурах) болон амьдрах орчноос суралцах (гадаад хэлтэй болох гэх мэт) мэдээллүүдтэй харьцуулахын тулд ашиглаж болно.

*Source: AI and Education: Guidance for Policymakers (UNESCO, 2020)*

# 7. Сургалтын хөтөлбөр, агуулга, суралцагчийн үнэлгээн дэх МХХТ

2015 оны Чиндаогийн Тунхаглалд эдгээр сэдвүүдтэй уялдах дараах тодорхойлолтуудыг оруулсан байна. Үүнд:

- **Сургалтын хөтөлбөрт:** *Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрт МХХТ-ийн суурь чадвар болон мэдээллийн анхан шатны мэдлэгийг тусгах шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна.*

- **Агуулгад:** *Суралцахуй болон түүний үр дүнд МХХТ-ийн хэрэглээний үзүүлэх нөлөөг тусгаж үнэлгээнд нэвтрүүлэхийг бид дэмжиж байна.*

- **Үнэлгээнд:** *Бид (1) чанарын баталгаажилт болон (2) түүнийг ухамсарлан хүлээн зөвшөөрөх хоёрыг онлайн сургалтын нийцтэй, найдвартай байдлыг дээшлүүлэх, насан туршийн боловсролыг дэмжих харилцан уялдаатай, шийдвэрлэх ач холбогдолтой элементүүд гэж үздэг.*

### Бодлогын асуудал 11: Оюутан сурагчдаас хүлээгдэж буй МХХТ-ийн ур чадварууд тодорхой биш байна

Сайдын (2019, A/491) тушаалаар сургалтын шинэ төлөвлөгөөнд МХХТ-ийн хичээлийг оруулах тухай баталсан. Гэсэн хэдий ч Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөний (2021-2030) үнэлгээнд “Боловсролын салбар дахь МХХТ, түүний зорилго, хичээлийн хөтөлбөр болон сургалтын үр дүн хоорондын уялдаа холбоог одоогийн хууль эрх зүйн орчинд сайтар тодорхойлоогүй” гэж дүгнэжээ. Төлөвлөгөөнд: 1) Суралцагчийн бүтээлч сэтгэлгээ, МХХТ-ийн ур

чадварыг хөгжүүлэхэд чиглүүлж бага, дунд ангийн хөтөлбөрийг шинэчлэх; түүнчлэн 2) шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийн боловсролын газрын мэргэжилтэн, арга зүйчид, сургуулийн удирдлага, багш нарт зориулж сургалт явуулах гэжээ.

## Зөвлөмж

Энэ жилийн эхэнд БШУЯ-аас багшийн МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлагыг батласан. Тэрхүү баримт бичигт багш нар МХХТ-ийг багшлахуй болон суралцахуйн үйл явцад үр дүнтэйгээр ашиглахын тулд юуг сурч мэдсэн байх талаар тодорхойлсон.

Үүний зэрэгцээ БШУЯ-аас сурагчдад зориулсан МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлагыг боловсруулах ёстой. Багшийн МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлагатай адил ийм баримт бичигт сурагчид МХХТ-ийн талаар юу сурч мэдсэн байх хэрэгтэй болон боловсролын үе шат бүрд МХХТ-ийн ямар ур чадваруудыг сурсан байх талаар оруулах хэрэгтэй юм.

Сингапурын Боловсролын яамнаас гаргасан МХХТ-ийн суурь стандартуудыг сургуулиуд нь мөрддөг (доорх хүснэгтийг үзнэ үү). Үүнтэй нэгэн адил БШУЯ ч мөн Монголын ард иргэдэд зориулсан Насан туршийн боловсролын төвд заагдах МХХТ-ийн ур чадваруудын зааварчилгаа бүхий МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлагыг боловсруулж болно.

**Гэгээн Андрюгийн бага сургууль**

**МХХТ-ийн өргөтгөсөн хөтөлбөр: МХХТ-ийн суурь стандарт**

Манай МХХТ-ийн өргөтгөсөн хөтөлбөр нь хичээлийн хөтөлбөр болон сэдвүүдтэй нягт уялдаж, суралцагчдын суралцахуйн туршлагыг сайжруулдаг. МХХТ-ийн суурь

стандартууд нь ахисан түвшнүүдийн гол үе шатуудад тусгагдсан МХХТ-ийн ур чадварын цогц юм.

Эдгээр ур чадварууд нь МХХТ-той нягт уялдсан сургалтын хөтөлбөрийн үр шимээр технологид суурилсан нийгэмд оршин амьдрах, хөгжихөд шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйлсийн түвшинг илэрхийлдэг. Стандартыг гадаадын болон манай сургуулиудын МХХТ-ийн стандарт, сургалтын хөтөлбөр, одоо хэрэгжиж буй практик үр дүнтэй харьцуулж үзсэн болно.

Суралцагчийг тухайн сургуульд сурч байх явцад нь түүний эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлснээр МХХТ-ийг ашиглан үр дүнд хүрэх түвшний мэдлэгийг эзэмшсэн эсэхийг бид тогтоож чадна.

МХХТ-ийн өргөтгөсөн хөтөлбөрийн 1:1 -д оруулсан ттооцоолон бодох хичээл дээр суралцагчийн эзэмшвэл зохих ур чадваруудыг доор үзүүлэв.

| Ур чадварын талбарууд | Код | Ур чадварууд | Тайлбар тэмдэглэл |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагаа (K)** | **PK1** | График хэрэглэгчийн холбоос дээр навигаци хийх (GUI) | • Хэрэглээний програм хангамж болон цахим эх үүсвэр дотор ажиллах<br>• Тэмдэгтүүдийг таних (жижигрүүлэх товч, хавтас гэх мэт) |
| | **PK2** | Хэрэглээний программууд, хавтас, файл ашиглах | • Файлуудыг байршуулах, нэвтэрч орох<br>• Хэрэглээний программууд, (ж-нь: интернет хөтөч болон word процессор) цахим эх үүсвэрүүдийг нээх, хаах (ж-нь:онлайн тоглоомууд, загварчилгаа гэх мэт) |
| | **PK3** | Олон төрлийн аппликейшн дээр ажиллах | • Контентийг нэгээс нөгөөд шилжүүлэх |
| | **PK4** | Файл болон хавтсуудыг цэгцлэн удирдах | • Файл болон хавтсуудыг цэгцлэх (ж-нь:шинэ хавтас үүсгэх, хувилах, файл болон хавтсуудад нэр өгөх) |
| **Хайлтаар сурах (H)** интернет хэрэглэх, хайлт хийх | **PH1** | Тодорхой эх үүсвэрээс дижитал нөөцийг хэрэглэх | • Өгөгдсөн URL болон холбоосоор интернетийн эх үүсвэрт нэвтрэх |
| | **PH2** | интернетээс мэдээлэл хайж, цуглуулах | • Түлхүүр үг ашиглан хайлтын систем бүхий орон нутгийн эх үүсвэрүүд |

| | | | |
|---|---|---|---|
| | | | • URL болон файлуудыг эмхлэн цэгцлэх |
| **Текстээр сурах(T)**<br>Текст боловсруулах | **PT1** | Текстийн баримт бичиг үүсгэх | • Текстэнд тоо, тэмдэглэгээнүүд, том, жижиг үсгүүд багтдаг<br>• Үсэг шивэхээс эхлээд үг, хэлцүүд, богино өгүүлбэрүүд ба догол мөрийг шивэх үйл явц |
| | **PT2** | Үг, өгүүлбэрүүдийг засах, хэлбэрт оруулах | • Үг, хэллэг, өгүүлбэрүүдийг нэмэх, хасах, орлуулах<br>• Текстийн харагдацыг өөрчлөх (ж-нь: хэмжээ, загвар, өнгө ) |
| | **PT3** | Текстийн догол мөрийг засах, хэлбэрт оруулах | • Ялгах тэмдэг, тусгай тэмдэгтүүдийг багтаасан догол мөрүүд<br>• Догол мөрүүдийг цэгцлэх (ж-нь: сум эсвэл дугаарлах)<br>• Догол мөрүүдийг нэмэх, хасах, орлуулах |
| | **PT4** | Танилцуулга хийхдээ мультимедиаг текст болон графиктай хослуулах | • Текст болон тоо оруулсан хүснэгтүүд<br>• Хүснэгтийн төлөвийг өөрчлөх (ж-нь:баганы өргөн, мөрүүдийн өндөр )<br>• Зураг, клипарт, уран зураг оруулсан графикууд |
| **Мультимедиагаар сурах (M)**<br>Мультимедиа контентийг үйлдвэрлэх ба ашиглах | **PM1** | Танилцуулгыг текст болон графикаар хийх | • Танилцуулга нь текст болон графикийг оролцуулсан нэгээс гурван слайдыг агуулах ёстой<br>• Графикт зураг, клипарт, уран зураг багтана |
| | **PM2** | Албан ёсны текст болон графикуудыг засварлах | • Текст болон графикуудын байрлал, харагдацыг (ж-нь: хэмжээ, өнгө) өөрчлөх<br>• Текстийг цэгцлэх (ж-нь: сумтай болон дугаарлалтын хэв загварууд) |
| | **PM3** | Мультимедиаг текст ба графиктай хослуулан танилцуулга хийх | • Танилцуулга нь медиа файлуудыг агуулсан, хөдөлгөөнтэй байх ёстой (ж-нь: видео бичлэг, аудио) |
| **Хүснэгт ашиглаж сурах (S)**<br>Мэдээллийн менежмент ба боловсруулалт | **PS1** | Хүснэгт үүсгэх | • Хүснэгтэд мэдээллийг оруулах (ж-нь: текст, тоонууд) |
| | **PS2** | Хүснэгтэн дэх мэдээллүүдийг засварлах | • Хүснэгтэн дэх мэдээллийг өөрчлөх |

| | | | |
|---|---|---|---|
| | | | • Хүснэгтийн харагдацыг өөрчлөх (ж-нь: баганын өргөн, мөрүүдийн өндөр) |
| | **PS3** | Мэдээллийн жижиг багцуудыг удирдах болон боловсруулах | • Мэдээллийн жижиг багцууд нь мэдээллийн 20 нүднээс хэтрэхгүй байх<br>• Хамгийн багадаа нэг үндсэн үйлдэл дээр энгийн томъёо ашигла (+, -, *, ?) |
| **Харилцаа холбооны хэрэглэгдэхүүнүүдийг ашиглаж сурах(C)**<br>Онлайн харилцаа холбоо | **PC1** | Онлайнаар харилцах | • интернетээр дамжуулан мэдээлэл солилцохын тулд аппликэйшн болон төхөөрөмжүүдийг хэрэглэх ж-нь: блогууд ашиглах (нэг зохиогч) |
| **Мэдээлэл цуглуулах хэрэглэгдэхүүнүүдийг ашиглаж сурах (D)**<br>Мэдээлэл цуглуулах болон дамжуулах | **PD1** | Мэдээлэл цуглуулах | • Зураг авах, дуу хураах, бичлэг хийх болон бусад мэдээллүүдийг хадгалахын тулд мэдээлэл цуглуулах хэрэглэгдэхүүнүүдийг ашиглах, ж-нь: зураг, дуу, бичлэг хийж хадгалдаг төхөөрөмжүүд болон мэдээллийн санг ашиглах |

Source: https://www.saintandrewsjunior.moe.edu.sg/department/committee/information-n-communications-technology/ict-baseline-standards

## Бодлогын асуудал 12: Цахим контентууд болон эх сурвалжуудад чанарын баталгаажуулалтыг бий болгох хэрэгтэй

Улсын төсвийн зөвхөн 1% нь л сургалтын материалуудад зарцуулагддаг тухай Алсын хараа 2050 баримт бичигт дурдагдсан байна. МХХТ-ийн Үндэсний бодлогод үндэсний цахим контент үйлдвэрлэлийг идэвхжүүлэх, үндэсний програм хангамжийн салбарыг хөгжүүлэхээр төлөвлөснөөс үзэхэд нөхцөл байдал өөрчлөгдөж боловсролын салбарт ашиг тусаа өгөх төлөв бий. МХХТ-ийн Үндэсний бодлогын баримт бичигт Монгол улс 2025 он гэхэд үндэсний цахим контентын 50%-ийг хангах зорилт тавьсан байна.

Орон нутгийн контентийн салбарт дэмжлэг үзүүлэх шийдвэр нь Монгол улсад урт хугацааны туршид тус дэм болно. “Контентыг нутагшуулахад багш суралцагчдад зориулсан, орон нутгийн шаардлагад нийцсэн сургалтын материалуудыг бий болгох, вэб хуудсан дээрх мэдээллүүдийг тухайн орон нутгийн эх хэлээр байршуулах ажлууд багтана. Нутагшуулалт нь дан ганц хэлний асуудлыг биш, уг контентыг тухайн орон нутагт хэрэгцээтэй, нийцтэй болгохын тулд хүн амын эрэлт болон уугуул соёлын уламжлалыг харгалзан үзэх, түүнчлэн боловсролд МХХТ-ийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай. Оновчтой бодлого нь эргээд тухайн орон нутагтаа хэрэгтэй контент болон аппликэйшнүүдийг бий болгох орон нутгийн програм хангамжийн салбарын хөгжилд түлхэц үзүүлнэ.”. (ADB, 2009)

Одоогийн байдлаар Монголд байгаа багш нар цахимаар хичээл заах болон сургалтын материалуудыг хэрэглэхдээ хэд хэдэн порталуудыг ашигладаг (доорх жагсаалтыг харна уу).

| Эх үүсвэр | Агуулга |
|---|---|
| Цахим контент, http://econtent.edu.mn | • 8-12-р ангийн математик, байгалийн ухааны хичээлийн 144 электрон объект<br>• 1-12-р ангийн 300 гаруй сурах бичиг<br>• Математик, шинжлэх ухаан, англи хэлний анхан шатны 483 электрон объект |
| Багш нарт зориулсан цахим хуудас http://teacher.itpd.mn | • Багшийн мэргэжил дээшлүүлэх институт хариуцдаг.<br>• 2013 онд АХБ-ны дэмжлэгтэйгээр хийгдсэн.<br>• Бүх цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд харилцан мэдлэг, туршлага солилцох, хамтын ажиллагааг сурталчлах<br>• Онлайн сургалтын хэрэгслийг түгээх |
| Онлайн зөвлөмж, http://bagsh.itpd.mn | • Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын байгууллагуудад зориулсан онлайн зөвлөгөө өгөх төв<br>• 2016 онд ашиглалтад орсон<br>• 75 ахлах сургууль, 8 бага боловсролын 3 агуулгыг багтаасан болно |
| Сайн хичээлийн технологийн номын сан,, http://urchadvar.itpd.mn | • Багш нарын ур чадварын уралдаанд оролцсон бүтээлүүдийн видео файлуудын номын сан<br>• Нийт 985 видео бичлэг |
| Даалгаварын сан, http://itembank.eec.mn | • Бага ангийн зориулалттай 1758 даалгавар<br>• Дунд ангийн зориулалттай 5,702 даалгавар<br>• Ахлах ангийн зориулалттай 6595 даалгавар |
| Khan Academy нээлттэй эхийн систем, http://khanacademy.org | • Хаан академийн нээлттэй агуулгыг орчуулсан<br>• Монгол хэл дээрх 813 видео хичээл |
| Нээлттэй боловсролын веб, http://one.mn | • 40 онлайн сурах бичиг<br>• Англи хэл, мэдээлэл зүйн чиглэлээр 140 лекц |
| Сайн туршлагын номын сан, www.edub.edu.mn/skill-default | • Багш нарын дадлага, туршлагын сан<br>• 1-12-р ангийн 450 хичээл<br>• 1-12-р ангийн 191 хөтөлбөр<br>• 113 лекц<br>• 65 зааварчилгаа<br>• 106 дадлага<br>• 68 хэрэгсэл<br>• Нийт = 993 |

Олон багш нар цахим сургалтын материалууд/нөөцүүдийг олноор боловсруулж чаддаг ч чанарын баталгаажуулалтын механизм дутагдалтай байгааг тэмдэглэсэн (БХ, 2019).

### Зөвлөмж

МУБИС-иас жил бүр зохион байгуулдаг уралдааныг чанарын баталгаажуулалтын нэг хэлбэр гэж үзэж болно. Багш нар өөрсдийн материалыг уралдаан зохион байгуулагчдад илгээж, зохион байгуулах хорооноос тэдний явуулсан материалыг тодорхой шалгуур үзүүлэлт болон удирдамжийн дагуу үнэлж, шалгаруулдаг. Шалгарсан цахим эх сурвалжийг аль нэг контентын портал дээр оруулах үед тэднийг чанарын баталгаажуулалт хийгдсэн гэж үзнэ.

БШУЯ-аас багш нар цахим материал, нөөцөө хөгжүүлэх явцад тэднийг удирдан чиглүүлж чадахуйц стандарт эсвэл удирдамжийг боловсруулан чанарын баталгаажуулалтын үйл явцыг энгийнээр бий болгож болно. БШУЯ-аас тэдгээр удирдамж, стандартуудыг шинэчилж байхын тулд мэргэжилтнүүдээс бүрдсэн хороог бий болгож болно (контент боловсруулагчид, сургалтын хөтөлбөрийн мэргэжилтнүүд, ЕБС сургууль, их, дээд сургууль, БШУЯ-ны мэргэжилтнүүд).

Цаашдаа олон багш нарыг ирээдүйд өндөр чанартай материалууд боловсруулах хүслийг өдөөхийн тулд БШУЯ-аас уралдаан тэмцээн зохион байгуулах эсвэл багшийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгууруудыг нэгтгэж нэг болгох, албан тушаал ахих эсвэл санхүүгийн нэмэлт урамшуулалд хүргэх зэрэг тодорхой нэмэлт урамшууллын талаар бодох ёстой.

## Бодлогын асуудал 13: Үнэлгээнд хиймэл оюун ухааныг ашиглах асуудлыг судлах хэрэгцээ

БШУЯ нь Монгол улсад цахим сургалтыг өргөн хүрээнд хэрэгжүүлж байгаа нь суралцагчдын сурлагын ахиц дэвшлийг үнэлэх, мэдээлэл цуглуулах боломж олгож байна. Иймр мэдээлэл нь суралцагчдын үнэлгээнд хиймэл оюун ухааны технологийг ашиглах боломжийг олгодог.

### Зөвлөмж

Насан туршийн суралцахуйн хүрээнд санал болгосноор БШУЯ-аас боловсролын бүх түвшнийг цахим сургалтад шилжүүлэх, өөрчлөхийн тулд хиймэл оюун ухааны хэрэглээг судалж эхлэхийг хүсч магадгүй. Хэрвээ Монгол улс энэ салбарыг эртхэн эхлүүлбэл боловсролын тогтолцоо мөдхөн үр шимийг нь хүртэж чадна.

**Боловсролын нийтлэг эрх ашгийн төлөө хиймэл оюун ухааныг хэрхэн хамгийн сайн ашиглаж болох вэ?**

**Хиймэл оюун ухаан үнэлгээг тасралтгүй хийх боломжтой болгосон**

Оюутан сурагчдын ахиц дэвшлийг байнга хянах, зорьсон хариултыг нь өгөх, сурагчдын ур чадварыг үнэлэхэд зориулагдсан хиймэл оюун ухаан бүхий хэрэгслийг үнэлгээний өөр нэгэн хэлбэр болгон ашиглах боломжтой.

*Эх үүсвэр: AI and Education: Guidance for Policymakers (UNESCO, 2020)*

# 8. Боловсролын салбарын мэдээллийн систем

Боловсролын салбарын мэдээллийн систем (БСМС) нь “Алсын хараа 2050” баримт бичигт тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй. Тэдгээр зорилтуудын нэг нь “нээлттэй боловсролын системийг бий болгох, онлайн болон зайн сургалтын нэгдсэн платформ боловсруулж, боловсролын бүх түвшинд онлайн сургалтыг нэвтрүүлэх” явдал юм. Ямар ч улс орон үр нөлөө бүхий боловсролын удирдлагын мэдээллийн системгүйгээр (БУМС) сургалтын боловсронгуй платформуудыг хөгжүүлнэ гэж төсөөлөхөд бэрх юм. ЮНЕСКО (2018)-ийн үзэж байгаагаар “үр нөлөө бүхий БУМС дараах талбаруудад үнэ цэнтэй мэдээллийг өгдөг. Үүнд а) менежмент ба удирдлагын үйл явц б) төлөвлөлт, в) бодлого боловсруулалт ба г) хяналт, үнэлгээ. Эдгээр үйл явцууд өөр хоорондоо уялдаа холбоотой байдаг бөгөөд төвөөс орон нутаг хүртэл, боловсролын байгууллагууд дотроо болон хоорондоо байршил харгалзахгүйгээр харилцан холбоотой явагдах юм.” Түлхүүр үг нь “харилцан холбогдсон”.

### Бодлогын асуудал 14: Мэдээллийн систем хоорондын уялдааг хангах

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын (2014-2024) баримт бичигт боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг төгөлдөржүүлэх зорилт тавьсан.

Боловсролын салбарын мэдээллийн систем (БСМС)-ийг анх 2008 онд Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-ны цуглуулсан мэдээллийг байршуулахын тулд нэвтрүүлсэн. БСМС нь Монгол улс дахь хувийн болон улсын бүх сургуулиудыг хамардаг. 2018 оны байдлаар БСМС-ийн хүрээнд дараах системүүдийг боловсруулжээ (БХ, 2019):

- Хүний нөөцийн дэд систем
- Боловсролын удирдлагын систем
- Санхүүгийн удирдлагын систем
- Статистик мэдээллийн систем

Үүнээс гадна дараах системүүд мөн боловсруулагдаж байна. Үүнд:

- Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем (ДБУМС)
- МБС-ын Удирдлагын мэдээллийн систем (МБС-УМС)

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг (2016-2021) баталсан Засгийн газрын 304 (2016) тоот тогтоолоор сургалт, менежментийн цахим мэдээллийн нэгдсэн системийг боловсруулах зорилтыг дэвшүүлжээ.

Цахим засаглал үндэсний хөтөлбөр (2019)-т боловсролын салбарын менежментийн цахим мэдээллийн нэгдсэн системийг боловсруулж хэрэглэхийг санал болгосон. Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-нд боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлж, нэгдсэн сүлжээг өргөжүүлэх замаар салбар хоорондын мэдээлэл солилцоог хялбаршуулах гэсэн ижил зөвлөмжийг гаргасан.

Бусад улс орнуудын туршлагыг харахад БУМС-ийг боловсруулахад гарч байгаа асуудлуудын нэг бол өөр өөр системүүдийн холболтын асуудал юм. Энэ нь ихэвчлэн өөр доноруудын санхүүжүүлж, өөр оролцогчид хөгжүүлснээс үүдэлтэй байдаг.

Зарим тохиолдолд ашигласан хэл эсвэл програм нь тохирохгүйгээс болж нэг системийн мэдээллийг өөр системд хэрэглэж болохгүй болдог. Заримдаа

хэрэглэгчдийг систем бүрд өөр өөр нэвтрэх нэр, нууц дугаартай байхыг шаарддаг нь төвөгтэй байдлыг үүсгэдэг.

**Зөвлөмж**

БШУЯ-аас өөр хоорондоо ялгаатай мэдээллийн системүүдийг нэгтгэхийн тулд БСМС-ийн зураглал боловсруулах хэрэгтэй. Иймд тус зураглалд ирэх жилүүдэд санхүүжилтийг тогтвортойгоор хангах стратеги бодлого, санхүүжилтийн хэрэгцээ, шаардлагын тооцооллыг тусгаж өгөх ёстой болно.

## Бодлогын асуудал 15: Нотолгоонд суурилсан удирдлага, төлөвлөлтөд БСМС-ийг ашиглах нь

БШУЯ интернет холболт болон компьютертэй сургуулиудын тоог бүс нутгаар болон сургуулиудын түвшингээр БСМС-ийн тусламжтайгаар хялбар гаргах боломжтой (БХ, 2019). Гэсэн хэдий ч мэдээллийг шийдвэр гаргах, төлөвлөхийн тулд боловсруулж, дүн шинжилгээ хийхгүй л бол дангаараа тийм ч ихийг өгүүлэхгүй.

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу БСМС-ийг олон талбарт сайжруулж болно. Зарим нэгэн захиргааны мэдээллийн шалгуур үзүүлэлтүүдийг өөрчлөх хэрэгтэй. Боловсролын бодлогын төлөвлөлт, шийдвэр гаргалт, цаашлаад бодлого, хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээнд мэдээллийг хэрхэн үр нөлөөтэйгөөр ашиглах талаар ажилчдад цаашдаа сургалт явуулах хэрэгтэй. Тайланг хэрэглэхэд тохиромжтой байдлаар гаргах шаардлагатай.

## Зөвлөмж

БШУЯ-аас боловсролын төлөвлөлт, удирдлагын мэргэжилтнүүд болон БСМС-ийн мэргэжилтнүүдийн цомхон бүрэлдэхүүнийг сургахад хөрөнгө оруулах ёстой. Ингэхийн тулд Засгийн газраас дараах сонголтуудыг судлаж үзэх хэрэгтэй. Үүнд:

*Сонголт 1:* Монголын оролцогчдод зориулсан захиалгат сургалтын хөтөлбөр боловсруулах талаар ЮНЕСКО-ийн Боловсролын төлөвлөлтийн олон улсын хүрээлэнд (БТОУХ) хүсэлт гаргах хэрэгтэй. Энэ нь боловсролын төлөвлөлт, бодлого боловсруулалт, мэдээллийн задлан шинжилгээ, мөн БСМС-тэй хамааралтай өөр өөр сэдвүүдийг хамарсан богино хугацааны цуврал сургалтын хөтөлбөр байж болно. Сургалтыг онлайнаар эсвэл биечлэн хүргэж болно.

*Сонголт 2:* Солонгос, Сингапур зэрэг БСМС-ийн сайн туршлагатай орнуудаас харилцан туслалцаа хүсэх хэрэгтэй. Эдгээр орнууд Монголд ажиллах мэргэжилтнүүдийг хангах эсвэл БШУЯ-ны албан тушаалтан, албан хаагчдыг бусад орны туршлага судлах аялалд хамруулах боломжийг өгч болно.

*Сонголт 3:* Цаашид БСМС-ийн ирээдүйн мэргэжилтнүүдийг байнгын сургалтад хамруулахын тулд сургалт эсвэл хөтөлбөр боловсруулж хөгжүүлэх Монголын нэг их сургуулийн чадавхыг бэхжүүлэх хэрэгтэй. БШУЯ нь шинэ сургалт эсвэл хөтөлбөрийг бий болгох эхний үйл явцад туслуулах зорилгоор ЮНЕСКО-ийн Боловсролын төлөвлөлтийн олон улсын хүрээлэнд (БТОУХ), ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн эсвэл гадаадын их сургуулиудаас тусламж хүсэх замаар хэрэгжүүлж болно.

## 9. Боловсролын салбар дахь МХХТ-ийн санхүүжилт

Тогтвортой санхүүжилт байхгүй байна гэдэг нь боловсрол дахь МХХТ тогтвортой хөгжихгүй байна гэсэн үг юм. Олон улс орнууд үр шим хүртэх цөөн хэдэн сургуулийг сонгох замаар туршилтын төслүүдээр эхэлдэг. Гэвч тэдгээр төслүүд нь дуусгавар болдог. Тогтвортой санхүүжилтгүйгээр улс орнууд эдгээр туршилтын төслүүдийг үндэсний хэмжээнд гүйцэтгэхэд бэрхшээлтэй учирдаг.

2015 оны Чиндаогийн Тунхаглалд "засгийн газар, аж үйлдвэрлэлийн түншүүд, багш нарын байгууллага болон эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудыг оролцуулсан иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан боловсролын бодлогод МХХТ-ийг амжилттай хэрэгжүүлэхэд олон талт түншлэлийн ач холбогдол нэмэгдэж байгааг" хүлээн зөвшөөрсөн. Үүнд санхүүжилтийн тодорхой нэг эх үүсвэр гэж байхгүй. Тийм учраас "суралцахуйд МХХТ-ийн бүрэн боломжийг ашиглахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг баталгаатай болгох санхүүжилтийн шинэлэг механизмийг боловсруулахад засгийн газрууд болон хувийн хэвшлүүдийн хоорондын яриа хэлэлцээ, зөвшилцөл чухал юм."

### Бодлогын асуудал 16: Боловсролын МХХТ-ийн санхүүжилтыг хэрхэн тогтвортойгоор хангах вэ?

Боловсролын хөтөлбөртөө МХХТ-ийг 20 орчим жил хэрэгжүүлсэн Монгол улс гадаад, дотоодын санхүүжүүлэгч байгууллага, хандивлагч байгууллагуудтай харилцаж сурсан. БНХАУ-ын "Шинэ зууны боловсрол" зээлийн төслөөр Монгол улс бүх ЕБС-иудаа интернет холболттой болгох боломжтой болсон. Боловсролын мэдээллийн төв болон "Эрдэмнэт" сүлжээг улсын болон Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр байгуулсан (БХ, 2019). Гэсэн хэдий ч, хэдхэн жилийн дараа тэдгээр

МХХТ-ийн тоног төхөөрөмжүүдийг яаралтай засч сэлбэх, сайжруулах эсвэл солих хэрэгцээ үүссэн. Шинэ санхүүжилтийн хэрэгцээ шаардлага хэзээ ч дуусахгүй.

Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын санхүүжүүлэгч байгууллагууд энэ асуудлуудыг ойлгодог. “Хэрвээ засгийн газрууд өөрсдийн эх үүсвэрээс МХХТ-т томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх мөнгө босгоход хүндрэлтэй байгаа бол төр, хувийн хэвшлийн түншлэл МХХТ-ийг хөгжүүлэх, нэвтрүүлэхэд чухал хөдөлгөгч хүч болж магадгүй” (АХБ, 2009). Үнэндээ бол Монголын МХХТ-ийн үндэсний бодлого яг үүнийг л хэрэгжүүлэхийг зорьдог. Монгол улс “МХХТ-ийн дэд бүтэц болон үндэсний өргөн хүрээний сүлжээг Засгийн газар болон хувийн хэвшлийн дэмжлэгээр өргөжүүлнэ гэж баримт бичигт тусгасан байна.”

Санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахын тулд засгийн газраас боловсролын хөтөлбөр, төслүүдэд МХХТ-ийг урт хугацаанд хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн олон эх үүсвэрүүдийг харгалзан үзэх хэрэгтэй (АХБ, 2009).

### Зөвлөмж

БШУЯ-аас боловсролын МХХТ-ийн тогтвортой стратеги, урт хугацааны санхүүжилтийн төлөвлөгөөг бэлдэж болно. Энэ нь Боловсролын мастер төлөвлөгөөн дэх МХХТ-ийн санхүүжилтийн хэсэг байж болно.

Санхүүжилтийн төлөвлөгөөнд дараах өөр өөр эх үүсвэрүүдийг тодорхойлж болно. Үүнд:

- Улсын төсөв
- Аялал жуулчлалын салбараас олох орлого
- Уул уурхайн салбараас олох орлого
- Бүх нийтийн үйлчилгээний сан

- Тусламжийн агентлагууд
- Олон үндэстний корпорациуд
- Орон нутгийн компаниуд
- Сангууд
- Иргэний нийгмийн байгууллагууд/Төрийн бус байгууллагууд
- Олон нийт /Эцэг эхчүүд

Санхүүжилтийн төлөвлөгөөнд хувийн хэвшлийг татан оролцуулах, тухайлбал боловсрол дахь МХХТ-ийг дэмжихийн тулд тэднийг урамшуулах гэх мэт олон арга замуудыг тодорхойлж болно. Үүнд:

- МХХТ-ийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих хувийн хэвшлийн бүлэг
- МХХТ-ийн тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэх хувийн хэвшлийн бүлэг
- Цахим нөөцийн боловсруулалтыг дэмжих хувийн хэвшлийн бүлэг
- Цахим сургалтыг дэмжих хувийн хэвшлийн бүлэг
- Багш нарын сургалтыг дэмжих хувийн хэвшлийн бүлэг

Тусламж өгөх хүмүүст Засгийн газраас өгч болох урамшуулал, хөнгөлөлтүүд:

- Татварын хөнгөлөлт
- Засгийн газрын гэрээ хэлэлцээрүүд
- Засгийн газраас хүлээн зөвшөөрөх

Боловсролын мастер төлөвлөгөөний МХХТ-ийн санхүүжилтийн хэсэгт санхүүжилт хэрэгтэй үед үүнийг бий болгох стратеги, санхүүжилтийн эх үүсвэрүүдийг хялбараар тодорхойлох дараах зүйлс санхүүжилтийн шаардлагуудыг тодорхойлно. Энэ мэдээлэл нь зөвхөн БШУЯ-д төдийгүй боловсролын МХХТ-д хувь нэмрээ оруулахаар сонирхож байгаа түнш, хандивлагч байгууллагуудад туслах болно.

| | Жил 1 | Жил 2 | Жил 3 | Жил 4 | Жил 5 | Жил 6 | Жил n |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Хөрөнгийн зардал** | | | | | | | |
| **— МХХТ-ийн дэд бүтэц** | X | X | X | | | | |
| **— Тоног төхөөрөмж** | X | X | X | | | | |
| **— Агуулга боловсруулалт** | X | X | | X | X | | X |
| **— Платформ хөгжүүлэлт** | X | X | | | | | |
| **Урсгал зардал** | | | | | | | |
| **— Цахилгаан** | X | X | X | X | X | X | X |
| **— Интернет** | X | X | X | X | X | X | X |
| **— Засвар, үйлчилгээ** | X | X | X | X | X | X | X |
| **— Сургалт** | X | X | X | X | X | X | X |

| Шаардлагууд | Жил 1 | Жил 2 | Санхүүжилтийн эх үүсвэр | Санхүүжилтийн стратеги |
|---|---|---|---|---|
| **МХХТ-ийн дэд бүтэц** | | | | |
| **Тоног төхөөрөмж** | | | | |
| **Агуулга боловсруулалт** | | | | |
| **Платформ хөгжүүлэлт** | | | | |
| **Сургалт** | | | | |

# 10. Боловсролын салбар дахь МХХТ-ийн засаглал

МХХТ-ийн нийтлэг шинжтэй онцлог нь БШУЯ болон ХХМТГ-ын удирдлагууд хоорондын хамтын ажиллагаа, түүнчлэн БШУЯ-ны газар, хэлтэс, нэгжүүдийн уялдаа холбоо чухал. Олон оролцогч бүхий олон төрлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд бүх түвшний зохицуулалт хэрэгтэй болдог. Бодлого хэрэгжүүлэлтийг чиглүүлж хэрэгжүүлэлтээс бодлого сургамж авах ёстой. 2015 оны Чиндаогийн Тунхаглалд дурдсанаар "Боловсролын системийн менежментийг сайжруулж, хариуцлагажуулахын тулд боловсролын салбарын МХХТ-ийн интеграц, ашиглалт, үзүүлэх үр нөлөөний талаар баримтлах нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад эх сурвалжийг бүрдүүлэхүйц үндэсний хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгож хөгжүүлэх" үүрэг хүлээнэ".

### Бодлогын асуудал 17: Үйл ажиллагаа явуулах болон хэрэгжилтийг зохицуулах байгууллагын чадавх, механизмийг бий болгох шаардлагатай

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөнд (2020-2030) Засгийн газрын бодлого, төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд боловсролын салбарын чадавхид нөлөөлөх хэд хэдэн асуудлуудыг тодорхойлсон. Үүнд:

- Яам хоорондын уялдаа зохицуулалтын механизм байхгүй
- Ажилтнуудыг ойр ойрхон солих нь бодлогын үйл ажиллагааг хоорондоо холбогдолгүй болгоход хүргэдэг
- Тогтворгүй бодлого, төлөвлөгөөнүүд, ажилчдын техникийн чадавх
- Мэдээлэлд суурилсан төлөвлөлт болон удирдлагын системийн дутагдал
- Ажилтнууд хангалтгүйгээс болж судалгааны боломж хязгаарлагддаг, олон төрлийн тоног төхөөрөмжүүд нь хоорондоо уялдаа холбоо бүхий зохицуулалтыг хязгаарладаг, байгууллагын бүтэц нь улсын төсвийн

хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хууль эрх зүйн чиг үүрэгтэй нийцдэггүй, мөн

- Ажиллагсад, мэргэжилтнүүдээр дутмаг, ажилчдаа тогтмол мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж чаддаггүй, ажилчдаа ажлын байранд нь хадгалж чаддаггүй.

Эдгээр тулгамдсан асуудлуудыг засч залруулахын тулд Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөнд (БСДХХТ) уг төлөвлөгөөний талаарх санал хүсэлтийг тусгах, үр дүнг нь хянах, хэрэгжилтэд нь хяналт тавих, БСДХХТ-ний стратегийн уялдаа холбоог хангах үүрэг хариуцлага бүхий алба байгуулахыг санал болгосон. Үүнийг НҮБ-ын Монгол улсад суугаа баг жилийн тайландаа онцлох үйл явдал хэмээн тэмдэглэсэн. “Байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний чадавх сул байгаа учраас БШУЯ-ны зүгээс БСХДХТ (2021-2030) болон ТХЗ-4-ийн хэрэгжилтийн явцыг хянах үүрэгтэй Хяналт шинжилгээ, үнэлгээний алба байгуулахыг зөвшөөрсөн” (НҮБ, 2021).

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөний (БСДХХТ) хяналт шинжилгээг тогтвортой байлгахын тулд хэд хэдэн арга хэмжээг боловсруулсан байна. Төлөвлөсөн зорилтууд болон бодит үр дүнг харьцуулсан жилийн тоймууд гарна. 2025 онд дунд хугацааны хяналт, 2030 оны дараа эцсийн үнэлгээ хийхээр байна.

Хэрэв Монгол улс Боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөг 2021 онд боловсруулж чадвал БШУЯ-аас хяналт шинжилгээ, үнэлгээний үйл явцыг мөн адил хэрэгжүүлэх шаардлагатай. БШУЯ-ны зүгээс гаргах ёстой өөр нэг шийдвэр бол Боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг зохицуулах шинэ алба байгуулах эсэх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

## Зөвлөмж

БШУЯ нь тухайн байгууллагын одоо байгаа бүтцийг харгалзан Боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд шинээр бий болох үүрэг хариуцлагыг дааж авч явах чадвартай алба, хэлтэс байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай. Хэрэв байгаа бол БШУЯ энэ хэлтэст шинэ үүрэг хариуцлагыг нэмж өгөх болно, гэхдээ энэ ажлыг хэрэгжүүлэхийн тулд хүний болон санхүүгийн нэмэлт нөөцөөр хангах ёстой. Хэрэв байхгүй бол БШУЯ-аас шинэ бүтэц эсвэл газар, хэлтэс байгуулах шаардлагатай болно. Бусад орны жишээн дээр үндэслэн гурван хувилбарыг дор харуулав.

*1-р хувилбар: Тухайн улс орны боловсролын бүх МХХТ-ийг зохицуулах бие даасан агентлаг байгуулах*

Бүгд Найрамдах Солонгос Улсын боловсролын судалгаа, мэдээллийн алба (KERIS) нь Боловсрол, хүний нөөцийн хөгжлийн яаманд харьяалагддаг боловч бие даасан байдлаар ажилладаг. KERIS нь төлөвлөлт, судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд хэрэгжүүлэхдээ Боловсролын яам, орон нутгийн боловсролын байгууллагуудтай хамтран ажилладаг. МХХТ-ийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулах нь маш нарийн бүтэцтэй болж болно. Ийм байдлаар зохицуулахад Боловсролын яаманд өргөн цар хүрээтэй боловсролын асуудалд үйл ажиллагаагаа төвлөрүүлэх боломжийг олгодог бол KERIS-ийн үйл ажиллагаа нь боловсролын салбарт МХХТ-ийг хөгжүүлэх, хэрэгжилтийн явцыг ялгаатай боловсролын байгууллагуудтай уялдуулахад чиглэдэг. KERIS-ийн чиг үүргийг дараах хэсгээс үзнэ үү.

**Солонгосын боловсролын судалгаа, мэдээллийн үйлчилгээний чиг үүрэг (KERIS)**

- Цахим сургалтын системийн зохион байгуулалт, үйл ажиллагаа хувийн сургалтын зардлыг бууруулах, олон нийтийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэнэ
- 21-р зуунд мэдлэгт суурилсан нийгмийг удирдахад шаардлагатай бүтээлч боловсон хүчнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Анги танхимын хичээлийн чанарыг сайжруулах, МХХТ-ийг ашиглах замаар олон нийтийн боловсролыг үндсээр нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- Судалгааны мэдээлэл хуваалцах үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгч төвтэй мэдлэг, мэдээллийн нөөцийг зохицуулах
- Цахим боловсролын удирдлагын үйлчилгээг зохион байгуулж боловсролын удирдлага ба төрийн албаны үйлчилгээний үр дүн, ил тод байдлыг дээшлүүлэх
- Бүх хүмүүст боловсрол эзэмших боломжийг олгодог цахим сургалтын системийг дэмжих

Source: https://www.keris.or.kr/eng/cm/cntnts/cntntsView.do?mi=1175&cntntsId=1342

*2-р хувилбар: БШУЯ-нд боловсролын МХХТ-ийн алба бий болгох*

Сингапур нь жижиг улс учраас боловсролын МХХТ-той холбоотой бүх асуудлыг зохицуулах бие даасан агентлаг байгуулах шаардлагагүй байв. Боловсролын яам дотор боловсрол дахь МХХТ-ийн бүхий л үйл ажиллагааг чиглүүлэх, зохицуулах үүрэгтэй тусдаа алба байгуулах нь оновчтой байсан. Боловсролын технологийн хэлтэс нь бодлого ба хэрэгжилтийн хоорондох голлох холбоос юм. Энэ хэлтэс нь бодлого боловсруулагчдад зориулж зөвлөмж бэлтгэдэг бөгөөд ингэснээр Боловсролын яам зөв шийдвэр гаргаж чаддаг. Дараа нь энэ хэлтэс уг бодлогуудыг хөтөлбөр, төсөл болгон хөрвүүлж, хэрэгжилтийг сургуулийн удирдлагатай хамтран зохицуулдаг. Мөн энэ хэлтэс нь сургуулиудаас санал хүсэлтийг авч, эргээд бодлого боловсруулагчид хүргүүлдэг. Боловсролын технологийн хэлтсийн (Сингапур) үйл ажиллагааг доороос үзнэ үү.

**Боловсролын технологийн хэлтсийн чиг үүрэг (Сингапур)**

- Боловсролын технологийг үр дүнтэй ашиглахад манлайллыг бий болгох.
- Хэрэглэгч төвтэй програмууд, хэрэгслүүд, платформууд, мөн Сурагчдын сурах орон зайг боловсруулж хэрэгжүүлэх.
- Сурагчдын сурах чадварыг дээшлүүлэхэд чиглсэн боловсролын технологийг үр дүнтэй ашиглах, ялангуяа цахим сурган хүмүүжүүлэх арга зүйгээр дамжулан сургуулын удирдлага, гол боловсон хүчин, багш нарын чадавхыг бэхжүүлэх
- Цахим материал хөгжүүлэн сургалтын хөтөлбөр, үнэлгээ, мэргэжлийн хөгжил, байгууллагуудын харилцаа холбоог дэмжих

Source: https://www.moe.gov.sg/about-us/organisation-structure/etd/

*3-р хувилбар: Бодлого, хэрэгжилтийг зохицуулах хоёр түвшний хороо*

Филиппинд МХХТ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Боловсролын газрын хэд хэдэн албыг хамруулсан (Монгол дахь БШУЯ-тай дүйцэхүйц). Зохицуулалтыг шийдэх үүднээс Филиппиний Боловсролын газар хоёр шатлалтай хороо байгуулсан. Нэгдүгээр шат болох МХХТ-ийн Засаглалын хороо нь бодлого, томоохон шийдвэрийг хариуцдаг. Энэ хороонд дээд түвшний боловсролын албан тушаалтнууд болон хэлтсийн дарга нар ажилладаг. Хоёр дахь шат буюу МХХТ-ийн Техникийн хороо нь ажлын техникийн асуудлыг хэлэлцэж, шийдлүүдийг Засаглалын хороонд санал болгодог байна. Эцэст нь Филиппин Сингапурын загвартай адил МХХТ-ийн албыг бий болгосон. МХХТ-ийн засаглал ба МХХТ-ийн техникийн хорооны (Филиппин) үйл ажиллагааг доороос үзнэ үү.

## МХХТ-ийн Засаглалын хорооны чиг үүрэг (Филиппин)

- МХХТ-ийн бүхий л бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслүүдийг батлах чиг үүрэгтэй ажиллах;
- Суурь боловсрол, засаглалын МХХТ-той холбоотой стандарт, бодлогыг тогтоох;
- Тус газарт хэрэгжүүлж буй МХХТ-ийн хөтөлбөр, төслүүдийн ерөнхий чиглэлийг удирдамж болгон ICT4E Стратегийн төлөвлөгөөгөөр хангах;
- Тогтмол эсвэл шаардлагатай тохиолдолд хуралдаж нарийн бичгийн даргад тайлагнана.

*МХХТ-ийн Техникийн хороо (ICT-TC)*

- Суурь боловсрол, засаглалд МХХТ-ийг ашиглах талаар баримтлах бодлого, стандарт, удирдамжийг боловсруулан санал болгодог;
- Энтерпрайз болон мэдээллийн архитектураар хязгаарлагдахгүйгээр тохирох системийг суурилуулж манлайлан хэрэгжүүлдэг.
- Боловсролын МХХТ-ийн стратегийн төлөвлөгөө, төсөв, техникийн шаардлагууд, тогтвортой байдал болон түүнчлэн засгийн газрын саналууд, төрийн бус байгууллагуудын арга хэмжээ ба Филиппиний хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөний харах өнцгөөс МХХТ-ийн хөтөлбөр, төслийн саналуудыг үнэлдэг.
- Стратегийн төлөвлөгөөний зорилгод хүрэхэд шаардлагатай техникийн хороо, дэд хороод (TC-SC) болон зохицуулах бүлгүүдийг байгуулж, хяналт тавина;
- Суурь боловсролын салбарт МХХТ-ийн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд ODA-ийн санхүүжилттэй төслүүд, төрийн бус байгууллага, агентлагууд болон төрийн байгууллагууд, корпорацийн сангууд, ашгийн бус байгууллагуудтай нягт уялдаатай харилцаа холбоо тогтоож зохион байгуулдаг;
- Төрөл бүрийн оффис дахь МХХТ-ийн нөөц ашиглах, хуваарилах, техникийн гүйцэтгэлийг хянах,
- МХХТ-ийн хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх.

Техникийн хороо - Дэд хороод (TC-SC)

- Сургалтын хөтөлбөр, агуулга, үнэлгээ
- Дижитал сургалтын нөөцийн менежмент
- Мэргэжил дээшлүүлэх
- Засаглала ба менежмент
- Дэд бүтэц
- Бодлогын судалгаа, боловсруулалт

Эх үүсвэр: https://www.deped.gov.ph/wp-content/uploads/2018/10/DO_s2009_26.pdf

# Дүгнэлт ба зөвлөмж

Боловсролд МХХТ-ийг нэвтрүүлэхтэй холбоотой маш олон хөтөлбөр, салбарын асуудал болон БШУЯ-ны харьяа газар, агентлагууд, байгууллагууд, хүн бүрийн дагаж мөрддөг энгийн тайлбар лавлагаа, нийтлэг үйл ажиллагааны заавартай болох нь чухал юм. Энэ нь олон улс орнууд боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөө боловсруулахаар шийдсэн явдал юм.

Боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөнд Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөний мөчлөгийг баримтлахыг зөвлөж байна. Нэг давуу тал бол МХХТ-ийн үйл ажиллагаа нь БСХДХТ-ний тэргүүлэх чиглэлийг дэмжих чадвартай байх болно.

Боловсролын МХХТ-ийн мастер төлөвлөгөөг боловсруулахад дараах алхмуудыг санал болгож байна. Үүнд:

***1. Төлөвлөлтийн баг байгуулах.***

Багийг БШУЯ-ны удирдах албан тушаалтан эсвэл Засгийн газрын төлөвлөлтийн үйл явцад ажиллаж байсан туршлагатай хүн удирдаж болно. Багийн бусад гишүүд нь БШУЯ-ны гол албадуудын төлөөллүүд байна. Төлөвлөлтийн баг нь гишүүдээ төрийн бусад байгууллагууд, боловсролын байгууллагууд, хандивлагч агентлагууд болон хувийн хэвшлийн төлөөллүүдээр өргөжүүлэх боломжтой.

Төлөвлөлтийн багийн үндсэн үүрэг нь мастер төлөвлөгөөний төслийг Боловсролын сайдад батлуулахаар хүргүүлэх хүртэлх үйл ажиллагааг хамарна. Үүнд ажлын төлөвлөгөө боловсруулах, уулзалтын хуваарь гаргах, шаардагдах

төсвийг бүрдүүлэх, мастер төлөвлөгөө бичих ажлыг зохицуулах, бүх үйл явцын туршид оролцогч талуудтай зөвлөлдөх боломжийг хангах зэрэг орно.

2. ***Цагаан ном эсвэл нөхцөл байдлын тайлан бэлтгэх.***

Байгууллага дотроос гол санаанууд эсвэл саналуудыг агуулсан тоймоор эхэлж болно. Энэ нь уулзалтын үед цаг хугацаа алдахаас зайлсхийхээс гадна хэлэлцүүлгийн өнгө аяс, чиглэлийг тодорхойлно.

3. ***Төлөвлөлтийн уулзалт, семинарт урих оролцогч талуудаа тодорхойлох.***

Урилгын жагсаалтыг урьдчилан бэлтгэж, оролцогчдод урилгаа урьдчилан хүргүүлэх нь төлөвлөлтийн хэлэлцүүлэгт оролцох оролцогчдын оролцоо болон бэлэн байдлыг өндөр түвшинд хангана.

4. ***Төслийг гаргаж, зөвлөлдөх уулзалтуудыг хийх.***

Нэг, хоёр, гурав дахь төслийг бэлтгэж, гол түншүүд болон оролцогч талуудаас санал зөвлөмж авахаар төслийг илгээж албан бусаар зөвлөлдөх эсвэл мастер төлөвлөгөөний төслийг сайжруулах санал, зөвлөмжийг хэлэлцэх уулзалтад тэднийг албан ёсоор урьж болно.

5. ***Сайдад өргөн барьж батлуулах.***

Хоёр, гурван удаагийн хэлэлцүүлгийн дараа, оролцогч талуудын анхаарлаа хандуулж буй асуудлуудыг төсөлд тусгасан гэсэн ерөнхий тохиролцоо хийгдэж, мастер төлөвлөгөөг сайд хянан үзэж, батлахад бэлэн болно.

### *6. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх.*

Мастер төлөвлөгөөг зохих ёсоор эхлүүлнэ. Бүх түншүүдийг багтаан хэрэгжүүлэх үйл явцад оролцох бүхий л хүмүүст хэвлэж, тараана.

## ЗӨВЛӨМЖҮҮДИЙН НЭГТГЭЛ

| МХХТ-ийн хүрээ | Зөвлөмжүүд |
|---|---|
| **1. МХХТ-ийн дэд бүтэц** | Сургуулиудад компьютер тараах засгийн газрын стратегийг дахин авч үзэх;<br>Засвар үйлчилгээ тогтвортой байдлын төлөвлөгөө, цахим хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулах; |
| **2. СӨБ-ын салбар дахь МХХТ** | Цэцэрлэгийн түвшинд МХХТ-ийн боломжит хэрэглээг судлах, 21-р зууны дижитал бичиг үсэг, мэдээллийн бичиг үсэг зэрэг зайлшгүй шаардлагатай ур чадваруудыг зааж эхлэх |
| **3. Бага, дунд боловсролын салбар дахь МХХТ** | Бага сургуулийн МХХТ-ийн дэд бүтцийг өргөжүүлэх бодлого боловсруулах;<br>Сургуулийн удирдлагуудыг МХХТ-ийн манлайлалд сургаж сургалтын жилийн хугацаанд сургуулийнхаа МХХТ-ийн төлөвлөгөө боловсруулахыг шаардах |
| **4. МБС-ын салбар дахь МХХТ** | Шинээр гарч ирж буй болон эрэлт ихтэй газруудад МБС-ын онлайн сургалтыг хөгжүүлэх; МБС-ын багш нарт зориулсан хамгийн сайн сургалтыг олох. |
| **5. Дээд боловсролын салбар дахь МХХТ** | Багш бэлтгэх боловсролын сургалтын хөтөлбөрийг тохируулах замаар багшийн МХХТ-ийн цогц чадамжийн стандартыг |

| МХХТ-ийн хүрээ | Зөвлөмжүүд |
|---|---|
| | даруй нэвтрүүлэх; Одоогийн сургалтын хичээлүүдийг хянан магадлаж багш нарт зориулсан МХХТ-ийн цогц чадамжийн стандартад нийцсэн шинэ хичээлийг батлах; Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээг тохируулах; МХХТ-ийн сургалтын чиглэлийг өргөжүүлэх; Олон улсын сургалтын үйлчилгээ үзүүлэгчдийг оролцуулан хувийн хэвшлийнхнийг дэмжих; |
| **6. Насан туршийн боловсролын салбар дахь МХХТ** | Хувийн хэвшил, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудад насан турши йн боловсролын төвүүдийг ажиллуулахы г зөвшөөрөх; Төсвийн хөрөнгийг зорилто т хүмүүсийн насан туршийн боловсролд з арцуулагдаж байгаа эсэхийг баталгаатай болгох ваучерийн системийг ашиглах; 21-р зуунд насан туршийн боловсролыг орчин үеийн болгохын тулд хиймэл оюун ухааны хэрэглээг судлах. |
| **7. Сургалтын хөтөлбөр, агуулга, суралцагчийн үнэлгээн дэх МХХТ** | Оюутан, суралцагчдад зориулсан МХХТ-ийн чадамжийн стандарт боловсруулах (насан туршийн суралцахуйд бас); Дижитал нөөцийг бий болгох чанарын баталгаажуулалтын үйл явцыг бий болгох; Оюутнуудын суралцах явцыг үнэлэхэд хиймэл оюун ухааны боломжийг судлах. |
| **8. Боловсролын салбарын мэдээллийн систем** | Боловсролын төлөвлөлт, удирдлагын мэргэжилтнүүд болон Боловсролын удирдлагын мэдээллийн систем (БУМС)-ийн |

| МХХТ-ийн хүрээ | Зөвлөмжүүд |
|---|---|
| | цөөн тооны мэргэжилтнийг сургахад хөрөнгө оруулалт хийх |
| **9. Боловсролын салбарын МХХТ-ийн санхүүжилт** | Боловсрол дахь МХХТ-ийг тогтвортой хөгжүүлэх урт хугацааны санхүүжилтийн төлөвлөгөө, стратегийг боловсруулах |
| **10. Боловсролын салбарын МХХТ-ийн засаглал** | БШУЯ-д МХХТ-ийн хэрэгжилтийг зохицуулах механизмыг бий болгох |

## Эх үүсвэр


Asian Development Bank. 2009. **Good Practice in Information and Communication Technology for Education.** Mandaluyong City, Philippines. Retrieved from https://www.adb.org/sites/default/files/publication/28625/good-practice-ict-education.pdf

Auxillos, John. 2014. **Multiple Perspectives of the One Laptop Per Child Initiative: The Case of Mongolia.** Retrieved from https://www.academia.edu/6688760/Multiple_Perspectives_of_the_One_Laptop_Per_Child_Initiative_the_Case_of_Mongolia

Chehab, Mohamad. 2017. **How to conduct a policy review.** Retrieved from https://www.researchgate.net/publication/317358264_How_to_conduct_a_policy_review

ITU, UNESCO and UNICEF. September 2020. **The Digital Transformation of Education: Connecting Schools, Empowering Learners.** Retrieved from https://www.broadbandcommission.org/wp-content/uploads/2021/02/WGSchoolConnectivity_report2020.pdf

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Монгол улсын Засгийн газар. 2020. **Боловсролын Салбарын Хөгжлийн Дунд Хугацааны Төлөвлөгөө, 2021-2030** (шинэчилсэн төсөл).

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Монгол улсын Засгийн газар, Дэлхийн банк, Боловсролын Төлөө Дэлхийн Нийтийн Түншлэл Байгууллага. 2020. **Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын талаарх Алсын хараа**

**2050: Боловсролын салбарт тэгш боломж, үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх нь.**

Монгол Улсын Боловсролын Хүрээлэн (MIER). 2019. **Монгол Улсын Боловсролын Суурь Мэдээллийн Тайлан.** Ulaanbaatar, Mongolia.

National Zealand Council for Educational Research. 2004. **The role and potential of ICT in early childhood education: A review of New Zealand and international literature.** Wellington, New Zealand. Retrieved from https://www.nzcer.org.nz/system/files/ictinecefinal.pdf

**Qingdao Declaration, 2015: Seize Digital Opportunities, Lead Education Transformation.** Retrieved from https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000233352

Монгол Улсын Их Хурал. 2016. **Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилт 2030**.

UNESCO. 2018. **Re-orienting Education Management Information Systems (EMIS) towards inclusive and equitable quality education and lifelong learning.** Paris, France. Retrieved from https://millenniumedu.files.wordpress.com/2018/04/unesco-emis-policy-paper-2018.pdf

ЮНЕСКО. 2019. **Монгол Улсын Техник, Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Бодлогын Тойм Шинжилгээ** https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374199

ЮНЕСКО. 2020. **Монгол Улсын Боловсролын Бодлогын Тойм Шинжилгээ: Насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь.** https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687

UNICEF. 7 January 2021. **UNICEF Education COVID-19 Case Study: Mongolia – Remediation of learning after school reopening.** Retrieved from https://aa9276f9-f487-45a2-a3e7-8f4a61a0745d.usrfiles.com/ugd/aa9276_47c329d7c41d418b9ab56e6593786d30.pdf

# Хавсралтууд

## ХАВСРАЛТ 1. БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД МХХТ-ИЙН ТУСГАСАН БАЙДАЛ

### I. Боловсролын салбарын бодлогын баримт бичгүүдийн ерөнхий судалгаа

*Хүснэгт 1. Боловсролын салбарын бодлогын баримт бичгүүд дэх МХХТ-ийн талаарх ерөнхий судалгаа*

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | **Хууль тогтоомж** | | | | |
| 1 | Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль | 2018 | Энэ хуулийн зорилт нь багш бэлтгэх, багшийн хөгжил, оролцоог дэмжих, ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | **9 дүгээр зүйл. Багшийн нийгмийн баталгаа, хөгжил, оролцоог дэмжих, хангах**<br>• 9.3. Багш мэргэжлээр төгсөгчийн мэдээллийг төгсгөсөн сургууль нь боловсролын салбарын мэдээллийн системд илгээнэ.<br>**11 дүгээр зүйл. Багшийн ажлын үр дүн**<br>• 11.1. Багшийн тухайн хичээлийн жилд ажилласан үр дүнгийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн системд боловсролын сургалтын байгууллага илгээнэ.<br>**15 дугаар зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг**<br>• 15.1.3. Боловсролын салбарын мэдээллийн цахим санг бүрдүүлэх; | • Мэдээллийн системийг хөгжүүлэх, ашиглах |
| 2 | Боловсролын тухай хууль | 2002 | Энэ хуулийн зорилт нь боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино. | • **10 дугаар зүйл. Боловсролын хөтөлбөр, агуулга**<br>10.1.Боловсролын агуулга нь суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.<br>• **16 дугаар зүйл. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага**<br>16.5.2.сурах бичгийн агуулга, арга зүй, боловсролын удирдлага, хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хөгжил, мэдээлэл, холбооны технологид суурилсан сургалт. | • Мэдээлэл, холбооны технологид суурилсан сургалт |
| | **Монгол Улсын Их Хурлын тогтоол** | | | | |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (2020-2024) | 2020, №24 | Халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг амжилттай даван туулж, хүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, бүс ба орон нутгийг хөгжүүлэх, өмнөх Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгой анхаарах зорил зорилтууд дэвшүүлжээ. | **НЭГ. КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого**<br>• 1.1.12. Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж, бэлтгэнэ. Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр, хувилбаруудыг судалж, бэлтгэнэ.<br>• 1.1.13. Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.<br>**ХОЁР. Хүний хөгжлийн бодлого**<br>**Боловсрол**<br>• 2.3.12. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ. | • Цахим сургалтын платформ бий болгох |
| 2 | "АЛСЫН ХАРАА 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого | 2020, №52 | Монгол улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно. | **Зорилт 2.1.** Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.<br>• 2.1.6... техник мэргэжлийн болон дээд боловсролын бодлого тодорхойлоход шаардлагатай мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн санд нэгтгэн хөтөлж, хэрэглэж хэвшинэ.<br>• 2.1.25. Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, түгээнэ.<br>• 2.1.28. Нийгэмд нэн чухал боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ.<br>• 2.1.34. Багшийн стандартыг мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны, МХХТ-ийн, гадаад хэлний гэх мэт чадваруудаар ялган тодорхойлж, багшийн хөгжил, хүний | • Салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх<br>• Цахим, зайн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах<br>• Цахим, зайн сургалтын нэгдсэн платформ хөгжүүлэх<br>• Цахим, зайн сургалт зохион байгуулах<br>• Багшийн МХХТ-ийн ур чадварыг хөгжүүлэх |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагыг мэргэжлийн багшаар хангана.<br>• 2.1.42. Боловсролын салбарын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, бүх түвшинд нэвтрүүлэн салбарын бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хэрэглэж хэвшин, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.<br>• 2.1.43. Нээлттэй боловсролын тогтолцоог бий болгон цахим болон зайн сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, бүх насны суралцагч, иргэдэд зориулсан цахим сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулан түгээнэ.<br>• 2.1.44.Багш нарын мэдээлэл, харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах, цахим, зайн сургалт хөтлөх, англи хэлний чадварыг дээшлүүлэх, ЕБС-ийн МХХТ-ийн сургалтын агуулга, стандартыг олон улсын түвшинд хүргэж суралцагчдад цахим бичиг үсгийн боловсрол олгох, цахим орчинд аюулгүй байдлаа хангах чадвар олгох, иргэд, олон нийтэд зориулсан МХХТ-ийн чадварыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлж, сургалт явуулдаг бүх төрлийн байгууллагын оролцоог хангана. | |
| 3 | Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (2016-2020) | 2016, №45 | | **Боловсролын чиглэлээр:**<br>• 3.2.27. Нээлттэй мэдлэг, боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлж, орчин үеийн мэдээлэл, технологийн ололтод тулгуурласан насан туршийн боловсролын тогтолцоог эрчимтэй хөгжүүлнэ. | |
| 4 | Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024) | 2015, №12 | Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын зорилго нь иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, | Зоритуудад:<br>• …<br>• 1.3.5. Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг өргөтгөх<br>Бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэд: | • Салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдсан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхэд оршино. | • 7.11. Боловсролын удирдлага, мэдээллийн нэгдсэн системийг 2016-2017 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн байна. | |
| | **Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол** | | | | |
| 1 | Монгол улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай | 2020.08.26 | Бүх шатны боловсролын байгууллагад цахим сургалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсролын салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг сайжруулах | • Бүх шатны боловсролын байгууллагын цахим болон онлайн сургалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Боловсролын тухай болон бусад хууль тогтоожид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах<br>• Цахим хичээл, сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах нийтлэг шаардлага, жишиг аргачлалыг боловсруулж мөрдүүлэх<br>• Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай хангуулах<br>• Багшийг МХХТ-д суурилсан сургалт явуулах арга зүйд сургах, багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, багш бэлтгэх сургуулийн хөтөлбөрт цахим боловсролын агуулга оруулах<br>• ЕБС-ийн сурагчийн бүртгэл, хичээлийн идэвх, оролцоо, дүн мэдээлэл, даалгавар, нэмэлт материал зэргийг нэгтгэсэн эцэг эх хяналт тавих боломж бүхий системийг нэвтрүүлэх талаар судалж, хэрэгжүүлэх<br>• Үндэсний хэмжээний нээлттэй цахим сургалтын системийг хөгжүүлж, сайн жишиг хөтөлбөр, хичээлийг байрлуулах<br>• Боловсролын салбарын цахим шилжилтэд шаардагдах зардлыг улсын төсөл, олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлэх | • Бүх шатны боловсролын байгууллагын цахим болон онлайн сургалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх<br>• Цахим хичээл, сургалтын хэрэглэгдэхүүний шаардлагыг тодоройлж, мөрдөх<br>• Мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийг бүрдүүлэх<br>• Багшийн МХХТ-ийн ур чадварыг дээшлүүлэх<br>• Үндэсний хэмжээний нээлттэй цахим |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтын системийг хөгжүүлэх |
| | **Засгийн газрын тогтоол** | | | | |
| 1 | Цахим засаглал үндэсний хөтөлбөр | 2019, №73 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг төлөвшүүлэх, төрийн үйл ажиллагааны инновацыг дэмжих замаар цахим засаглалыг хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино. | Зорилт:<br>• Бүх нийтийг тоон бичиг үсэгтэн болгох;<br>• Эдийн засаг, нийгмийн бүх салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновацыг нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх;<br>• …<br>Бүх нийтийг тоон бичиг үсэгтэн болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:<br>• Олон улсын стандартад нийцсэн МХХТ-ийн суурь мэдлэг, ур чадвар олгох бүх нийтийн сургалтыг зохион байгуулах;<br>• Интернэт болон өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулан алсын зайн болон нээлттэй онлайн бүх нийтийн сургалтыг тогтмол зохион байгуулах;<br>• Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн нийтэд хүртээмжтэй давуу талыг ашиглан хувь хүний хөгжил, мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн, үр өгөөж бүхий төрөлжсөн контентыг бүтээх, түгээх;<br>• Боловсролын салбарын удирдлага мэдээллийн цахим нэгдсэн системийг хөгжүүлж, ашиглах;<br>• МХХТ-ийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа боловсролын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах;<br>• Мэдээллийн технологийн гарааны бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх, мэргэшлийн чадавхыг сайжруулах сургалт, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;<br>• Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүртэх хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон зорилтот бүлгийн нийгмийн тэгш оролцоог бүрдүүлэх зорилгоор тусгай техник, програм хангамж нэвтрүүлэх, контентоор хангах;<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон зорилтот бүлэгт зориулсан МХХТ-ийн боловсрол олгох төрөлжсөн сургалтын танхим байгуулж, сургалт зохион байгуулах; | • МХХТ-ийн ур чадвар олгох сургалт зохион байгуулах<br>• Алсын зайн болон нээлттэй онлайн бүх нийтийн сургалтыг зохион байгуулах<br>• Салбарын удирдлага мэдээллийн цахим нэгдсэн системийг хөгжүүлж, ашиглах<br>• МХХТ-ийн боловсрол олгох төрөлжсөн сургалтын танхим байгуулах, тусгай техник, програм хангамж нэвтрүүлэх |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | • … | |
| 2 | Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр (2018-2022) | 2018, №209 | Бүх нийтэд байгаль орчноо хамгаалах, түүх, соёлын өвийг дээдлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, түүнд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг даван туулах, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёл, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлж, Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад хөтөлбөрийн зорилго оршино. | Үйл ажиллагаа:<br>• 3.2.5. шинжлэх ухаан, технологи, инновацын судалгааг хөгжүүлж, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологи бүхий төсөл, гарааны компанийг дэмжих, олон нийтэд нээлттэй мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх;<br>• … | • Мэдээллийн нэгдсэн сан хөгжүүлэх |
| 3 | Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017-2025) | 2017, №47 | Мэдээлэл, харилцаа холбооны дэвшлийг бүх нийтийн хүртээл болгох, мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүний хөгжлийг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар Монгол улсын хөгжлийг хурдасгахад энэхүү бодлогын баримт бичгийн гол зорилго оршино. | Үйл ажиллагаа:<br>• 3.9.1. бүх нийтийг тоон бичиг үсэгтэн болгоно;<br>• 3.9.9. монгол хүний хөгжлийг дэмжиж, эдийн засаг, нийгмийн дараах салбарт МХХТ-ийн дэвшил, инновацыг нэвтрүүлэх замаар хөгжлийг хурдасган бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ:<br>    ○ 3.9.9.3. монгол хүний боловсрол, мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж дэмжинэ; | • МХХТ-ийг ашиглан боловсрол, мэдлэг, чадварыг хөгжүүлэх |
| 4 | Нээлттэй боловсролын “Нэг Монгол” | 2014, №105 | Иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэх, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай | Нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн нэг: | • Нэгдсэн мэдээллийн сан бий болгох |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | үндэсний хөтөлбөр (2014-2024) | | амьдрах, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах хэрэгцээнд нь нийцсэн нээлттэй боловсролын үндэсний шинэ тогтолцоог бий болгоно. | **3.1. "Нээлттэй академи" төсөл:** Хүүхдийн итгэл, найдвар, сурах тэмүүллийг нь дэмжиж, сургалтыг суралцагч өөрийн үйл явцад суралцдаг арга зүйд суурилсан "ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарт зориулсан үнэ төлбөргүй, нээлттэй онлайн боловсролын үйлчилгээ"-г боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх ажлууд:<br>• 3.1.1. дэлхий даяар хамгийн өндөр хандалт, ашиглалттай, үнэ төлбөргүй, онлайн, нээлттэй сургалтын үйлчилгээ болох АНУ-ын Хан Академийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын математик, физик, хими, биологи, анатоми, байгаль ба нийгмийн ухаан, мэдээллийн технологи, эдийн засаг, түүхийн хичээл, мөн АНУ-ын их дээд сургуулийн SAT, GMAT элсэлтийн шалгалтын онлайн видео хичээлийг бүрэн орчуулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад нээлттэй, үнэ төлбөргүй ашиглах боломжийг бий болгоно;<br>• 3.1.2. ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багшийн сургалтын видео хичээлийн сан, нээлттэй сургалтын онлайн системийг бий болгоно;<br>• 3.1.3. ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурах бичиг, багшийн ном, сургалтын гарын авлагуудыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим сурах бичиг, багшийн ном, гарын авлагуудыг бүтээж, хэрэглээнд нэвтрүүлнэ;<br>• 3.1.4. ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн байгалийн ухааны болон математикийн хичээлийн онлайн виртуал лабораторийг хөгжүүлж сургалтад нэвтрүүлнэ;<br>• 3.1.5 ерөнхий боловсролын сургуулиудыг мэдээлэл, холбооны өндөр технологид суурилсан ухаалаг (smart school) сургууль болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;<br>• 3.1.6. Гүүгэл (Google) корпорацийн дэмжлэгтэйгээр ерөнхий боловсролын нийт сургууль болон багш сурагчдыг дэлхийд хамгийн өргөн ашиглагддаг, үнэ төлбөргүй, нээлттэй сургалтын багц үйлчилгээтэй болгоно;<br>• 3.1.7. ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарт зориулсан компьютер, таблет, гар утас зэрэг бүх төрлийн мэдээлэл, холбооны хэрэгслийн орчинд хэрэглэгдэх сургалтын программ хангамжийг хөгжүүлнэ. | • МХХТ-ийг ашиглан боловсрол, мэдлэг, чадварыг хөгжүүлэх<br>• Сургалт, мэдээллийн сан, онлайн системийг бий болгох<br>• Цахим сургалтын материал бэлтгэх<br>• сургалтын анги танхим, тоног төхөөрөмжөөр хангах<br>• Програм хангамж хөгжүүлэх<br>• Гадны цахим сургалтад хамрагдах |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | **3.2. “Монгол хэл” төсөл:** Монгол улс үндэстэн оршихуйн үндэс болсон эх хэл, соёл, сэтгэлгээний үндэсний дархлааг бэхжүүлэх, бүх түвшний боловсрол, сургалтын чанар, иргэдийн харилцааны соёлын түвшинг дээшлүүлэх зорилгоор бүх нийтийн монгол кирилл бичгийн нээлттэй сургалтын орчинг бий болгох “Монгол хэл” төслийг хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх ажлууд:<br>• 3.2.1. монгол хэл бичгийн нийтээр дагаж мөрдөх кирилл, уйгардин бичгийн онлайн тайлбар толь бичгийг бүтээнэ;<br>• 3.2.2. монгол хэлийг эхлэн суралцагчийн түвшнээс эхлээд гүнзгий, ахисан түвшний онлайн сургалт, үндэсний шалгалтын системийг боловсруулж, бүх түвшний сургалт, хэрэглээнд нэвтрүүлнэ;<br>• 3.2.3. монгол кирилл бичгийн үсгийн дүрмийн алдаа засах компьютерийн программ хангамжийг зохиож, бүх нийтийн хэрэглээнд нийлүүлнэ.<br><br>**3.3. “Нээлттэй их сургууль” төсөл:** Хэн ч, хаанаас ч хүссэн цагтаа хэрэгтэй бүх мэдээллээ орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр хүлээн авч өөрийн боломжоороо бүтээлчээр судлах, профессор багшаас оюутнуудтайгаа онлайнаар хамтран бүтээж суралцах нээлттэй боломжийг дээд боловсролын тогтолцоонд бий болгох зорилгоор үүлэн технологи бүхий нээлттэй их сургуулийг хөгжүүлэх “Нээлттэй их сургууль” төслийг хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх ажлууд:<br>• 3.3.1. үндэсний эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлд өндөр эрэлттэй их, дээд сургуулийн хөтөлбөрүүдийг хөгжингүй орнуудын дэлхийн шилдэг их сургуулиудын түвшинд боловсруулж цахим, видео, виртуал хэлбэрт шилжүүлэн нээлттэй хэлбэрээр суралцах боломжийг бий болгоно;<br>• 3.3.2. дэлхийн шилдэг их сургуулиудаас сургалтад шууд хэрэглэх боломжтой, өндөр эрэлттэй мэргэжлийн сургалтын агуулга, хөтөлбөр, хичээл, лекцийг цахим, видео, виртуал хэрэглэгдэхүүний хамт эзэмших эрхийг нь худалдан авч их сургуулийн сургалтад нэвтрүүлнэ;<br>• 3.3.3. Гүүгэл (Google) корпорацийн дэмжлэгтэйгээр бүх их, дээд сургууль, коллежийн оюутан, багш нарыг дэлхийд | |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | хамгийн өргөн ашиглагддаг, үнэ төлбөргүй, нээлттэй сургалтын багц үйлчилгээтэй болгоно;<br>• 3.3.4. иргэд авьяас, хүсэл, хэрэгцээ, сонирхолдоо нийцүүлэн мэргэжил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий насан туршийн боловсролын нээлттэй их сургуулийг хөгжүүлнэ.<br><br>**3.6. "Нээлттэй мэдлэг" төсөл:** Нээлттэй мэдлэгийн үндэсний нэгдмэл сан бий болгох, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн ноу хауг хөгжүүлэх, мэдлэг, бизнес-инновац, технологийг бүтээх, хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, шинжлэх ухаан, өндөр технологид суурилсан өрсөлдөх чадамжтай үндэсний эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэсэн "Нээлттэй мэдлэг" төслийг хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх ажлууд:<br>• 3.6.1. эрдмийн бүтээл, докторын ажил, дипломын ажлын үндэсний нээлттэй санг байгуулна;<br>• 3.6.2. дэлхийн шинжлэх ухааныг монголын эрдэмтэн, судлаачдад нээж, Томсон Ройтерс (Thomson Reuters) корпорацийн "Web of science", "Web of knowledge", "Community of science" болон Скопус (Scopus), Шпрингер (Springer)-ийн шинжлэх ухааны мэдээллийн санд их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэмтэн, судлаачдыг чөлөөтэй нэвтрэн ажиллах боломжийг бүрдүүлнэ. | |
| 5 | "Зөв монгол хүүхэд" үндэсний хөтөлбөр (2014-2016) | 2013, №295 | Монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршдаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болж төлөвших гэр бүл, боловсрол, нийгмийн орчныг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино. | **"Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарын шинэчлэл" дэд хөтөлбөрийн зорилт хэрэгжүүлэх үйл ажиллагаа**:<br>• 6.4.8. Монгол улсын нийгэм, эдийн засгийн онцлог, боловсролын төлөвлөлт, үнэлгээний олон улсын нийтлэг арга зүйд нийцүүлэн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш, удирдах ажилтны мэдээллийн санг бий болгоно;<br>• 6.5.4. бага, дунд боловсролын түвшинд хэрэглэгдэх багшийн болон сурагчийн ном, цахим, аудио, видео зэрэг сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүнээс бүрдсэн сурах бичигт тавигдах шаардлага, стандартыг шинэчлэн боловсруулна; | • Мэдээллийн сан хөгжүүлэх<br>• Цахим сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх<br>• Цахим сургалт зохион байгуулах<br>• Цахим хуудас ажиллуулах |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | **“Авьяас” дэд хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа**<br>• 7.3.1. хүүхдийн авьяас билгийг нээж, хөгжүүлэхэд чиглэсэн теле сургалт, хөрөг, баримтат болон уран сайхны нэвтрүүлэг, асуудал дэвшүүлсэн хэлэлцүүлэг зэрэг телевиз, радио, сэтгүүл зүйн бүтээл туурвиж, нийтийн хүртээл болгоно;<br>• 7.3.3. хүүхдийн хөгжил, авьяас билгийн талаар санал солилцох, мэдээлэл түгээх зорилго бүхий “Авьяас” цахим хуудсыг тогтмол ажиллуулна;<br>• 7.3.7. байгалийн шинжлэх ухаан, мэдээллийн технологи, техник сэтгэлгээг хөгжүүлэх, зохион бүтээх авьяастай хүүхэд, залуучуудыг дэмжих, бүтээлийг нь үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;<br>**“Ном” дэд хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа**<br>• 8.1.2. ном унших соёлыг түгээн дэлгэрүүлэх телевизийн цуврал нэвтрүүлэг, теле хичээл, хүүхдийн ертөнцийг нээн харуулсан богино хэмжээний, цуврал уран сайхны кино, сэтгүүл зүйн бүтээл туурвиж, олон нийтийн хүртээл болгоно;<br>• 8.1.3. “Ном” цахим хуудсыг тогтмол ажиллуулж, хүүхэд, насанд хүрэгчид ном унших, харилцан суралцах интернэт орчин бий болгож өргөжүүлнэ; | |
| 6 | “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021) | 2010, №31 | | Авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд:<br>• Бүх нийтийн иргэний боловсрол болон эрүүл мэнд, байгаль орчин, улс төр, мэдээллийн технологийн боловсролд чиглэсэн албан бус сургалтуудыг эрчимжүүлэх<br>• Уул уурхай, газрын тос, эрчим хүч, биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологийн чиглэлээр залуу судлаачдыг бэлтгэх, дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлэх<br>• Бүх шатны боловсролын нээлттэй болон зайны сургалтын төв байгуулж ажиллуулах; | • Мэдээллийн технологийн боловсролд чиглэсэн албан бус сургалтуудыг эрчимжүүлэх<br>• Мэдээллийн технологийн чиглэлийн судлаачдыг бэлтгэх |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | | • Нээлттэй болон зайны сургалтын төв байгуулж ажиллуулах |
| 7 | Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө | 2006, №192 | Монгол улсын Боловсролыг 2006-2015 онд хогжүүлэх Мастер төлөвлөгөө нь 2015 он хүртлэх хугацаанд Засгийн газраас боловсролыг хөгжүүлэх талаар баримтлах урт хугацааны стратегийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлоход чиглэгдэнэ. | **Мастер төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлүүд**<br>• …<br>• Боловсролын бүх байгууллага, сургууль, цэцэрлэгийг интернеттэй холбосноор сургалт, мэдээлэл солилцоо, хяналт-шинжилгээ, үнэлгээ, бүртгэл тооцооны мэдээлэл харилцааны технологийг нэвтрүүлэх<br>**Боловсролын товлосон зорилтууд**<br>*Ерөнхий боловсролын талаар*<br>• ЕБС-ийн компьютержүүлэлтийг эрс нэмэгдүүлнэ. Үүнд: Бага боловсролын хүүхэд компьютерийн харьцааг 1250-иас 250 (250 хүүхдэд нэг компьютер), дунд ангийн хүүхэд компьютерийн харьцааг 250-иас 50, ахлах ангийн хүүхэд компьютерийн харьцааг 25-иас 5-д хүргэнэ.<br>*Албан бус боловсролын талаар*<br>• Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв, сум, дүүргийн Гэгээрэл, хөгжил, албан бус боловсролын төвийн санхүүжилтийг жил тутам 8 хувиар өсгөнө.<br>**Үйл ажиллагааны бүрэлдэхүүн**<br>*Бага, дунд боловсрол*<br>• Хөдөөгийн сургуульд мэдээлэл, харилцааны холбооны шинэ технологи нэвтрүүлэх<br>• Зайны сургалтын үндэсний сүлжээний хүртээмж, ашиглалт, найдвартай ажиллагааг нэмэгдүүлэх<br>• Мэдээллийн технологи ашиглан хичээл заах талаар багш нарт зориулсан сургалт зохион байгуулж, сургалтын материал гарын авлага бэлтгэх<br>• Багш нарт компьютерийн хэрэглээний программ болон англи хэлний шаталсан боловсрол олгох<br>• Сургууль дээр боловсролын TV, интернет зэрэг мэдээлэл харилцааны шинэ технологиийг сургалтад ашиглах боломжийг өргөжүүлэх | • Мэдээллийн систем хөгжүүлж, нэвтрүүлэх<br>• МХХТ-ийг нэвтрүүлэх<br>• МХХТ-ийн тоног төхөөрөмж, програм хангамж, интернетийн асуудлыг шийдвэрлэх<br>• Багш нарын МХХТ-ийн ур чадварыг нэмэгдүүлэх |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | • Аудио, электрон хэлбэрийн сурах бичиг бий болгож, тэдгээрийг ашиглах арга технологийг нэвтрүүлэх<br>• Сургуулиудыг интернетэд холбох<br>• Сургуулиудыг электрон сургалтын тоног төхөөрөмжөөр тоноглосон анги танхимтай болгож, компьютер нийлүүлэх<br>• Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээнд цахим программууд ашиглаж, үнэлгээний үр дүн, мэдээллийн чанарыг сайжруулан хэрэглээг нэмэгдүүлэх<br>*Дээд боловсрол*<br>• Багш нарын мэргэжил дээшлүүлэхэд мэдээлэл харилцааны технологийг өргөн ашиглах, хөрөнгө оруулалт хийх | |
| | **Сайдын тушаал** | | | | |
| 1 | Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөлөө (2021-2030) | 2020 | Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө нь “Монгол улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай иргэнийг цогцоор хөгжүүлэх” зорилгыг дэвшүүлж байна. | **Зарчим:**<br>• Иргэн бүрд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломж олгох;<br>• Ухаалаг, дижитал технологийг бүх түвшний боловсрол, сургалтад ашиглах;<br>• Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн болон үйл ажиллагаанд ногоон хөгжлийг дэмжих;<br>• …<br>**Төлөвлөгөөнд боловсролын дэд салбар бүрээр бодлогын тэргүүлэх чиглэл, үр дүнг тодорхойлсон:**<br>• Боловсролын салбарын тогтолцоо, үйлчилгээний чанар, нийцийг сайжруулах;<br>  ○ Үйл ажиллагаа: Хүний нөөцийн мэргэжил дээшлүүлэх уян хатан холимог хэлбэрийн сургалтыг нээлттэй боловсрол, дижитал технологи ашиглан хөгжүүлэх<br>• Боловсролын үйлчилгээний тэгш хүртээмж, хамран сургалтыг нэмэгдүүлэх;<br>**Хэрэгжүүлэх хөтөлбөр:** Сургалтын цахим платформыг хөгжүүлж, онлайн сургалтын хөтөлбөрийг боловсруулан цахим контент, цахим хичээл боловсруулах<br>**Үйл ажиллагаа:**<br>  ○ Боловсролын салбарын мэдээллийн системд хөгжүүлэлт хийж, нэгдсэн сүлжээг өргөтгөх замаар | • Салбарын мэдээллийн систем хөгжүүлэх<br>• Ухаалаг сургууль, ухаалаг анги төсөл хэрэгжүүлэх<br>• Сургалтын цахим платформыг хөгжүүлэх<br>• Онлайн сургалтын хөтөлбөр боловсруулах<br>• Цахим контент, цахим хичээл боловсруулах<br>• Салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд нээлттэй боловсрол, |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдасан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | салбар дундын мэдээллийг харилцан солилцох боломжийг бүрдүүлэх<br>○ Олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, Аутсорсингийн төвийг байгуулж, чадавхыг бэхжүүлэх<br>○ Хиймэл оюун ухаан, их өгөгдлийн шинжлэх ухаан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх<br>○ Цахим бичвэр, цахим хэл шинжлэлийг хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж цахим контент, цахим хичээл боловсруулан насан туршийн боловсролд ашиглах<br>○ Багш бүрийг компьютержуулж ухаалаг сургууль, ухаалаг анги төсөл хэрэгжүүлэх<br>○ Нээлттэй, цахим, онлайн, зайн сургалтын агуулга, нөөц хэрэглэгдэхүүний чанарыг баталгаажуулж, бүртгэлжүүлэх<br>**Үр дүн:**<br>○ Хүн амын өсөлт, боловсролын үйлчилгээний тэгш хүртээмжтэй уялдуулан сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлж, нээлттэй боловсролын үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сургалтын тохируулгат орчныг бий болгосон байна.<br>○ Технологи, инновацын шинэчлэлтэй уялдуулан боловсролын цахим шилжилт хийж, бүх насны иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцахуйн уян хатан тогтолцоо бэхэжсэн байна.<br>• Засаглал, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох.<br>**Зорилтууд, үр дүнгүүдийн хураангуй:**<br><u>СӨБ:</u> - тусгаагүй<br><u>Бага, дунд боловсрол:</u> тусгаагүй<br><u>Мэргэжлийн боловсрол, сургалт:</u><br>• Иргэдэд насан туршдаа суралцаж, мэргэжил, ур чадвар эзэмших, мэргэшлийн түвшин дээшлүүлэх уян хатан, нээлттэй сургалтын боломжийг олгох замаар хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх<br><u>Дээд боловсрол:</u> | дижитал технологи ашиглах<br>• Хиймэл оюун ухаан, их өгөгдлийн шинжлэх ухаан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдсан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | • Нээлттэй, уян хатан боловсролыг хөгжүүлэх замаар тэгш боломжийг нэмэгдүүлэх (Нээлттэй, цахим, онлайн, зайн сургалтын хэлбэрүүдийг өргөжүүлсэн байна) | |
| | **Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол** | | | | |
| 1 | "Нийслэлийн боловсрол – 2020" дэд хөтөлбөр | 2017, №81 | Боловсролын чанартай, хүртээмж үйлчилгээг шуурхай хүргэх | • Төрийн өмчийн цэцэрлэгийн элсэлтийг цахим системд шилжүүлнэ.<br>• Цэцэрлэгийн хүнсний цахим захиалгын систем нэвтрүүлж, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, хадгалалтын тогтолцоог боловсронгуй болгоно.<br>• Олон улсын хөтөлбөрт сургуулийн тоо нэмэгдүүлж, ЕБС-уудад "Ухаалаг анги" кабинет, лаборатори, робот, тоног төхөөрөмж цахим болон сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулна. | • |

*Хүснэгт 2. Боловсролын салбарын хичээлийн жилийн зорилтууд*

| № | Баримт бичгийн нэр | Зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын салбарын 2020-2021 оны хичээлийн жилийн зорилго, зорилт | Зорилго: Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх | Зорилтууд:<br>• Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулах<br>• Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих, тэдний МХХТ-ийн ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг бүх шатны боловсрол, сургалтын байгууллага тэргүүлэх чиглэлээ болгож, хүний нөөцийг чадавхжуулах, заах аргын нэгдэл, сонирхлын бүлгээр хамтран цахим хичээл, хэрэглэгдэхүүн бэлтгэн турших сайжруулах<br>• … | МХХТ-ийг ашиглаж буй зорилго:<br>• Цахим сургалт зохион байгуулах<br><br>Цахим сургалтын бэлтгэл хангах хүрээнд:<br>• МХХТ-ийн ур чадварыг хөгжүүлэх<br>• Цахим сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх |
| 2 | Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын салбарын 2019-2020 оны хичээлийн жилийн зорилго, зорилт | Зорилго: Бүх шатны сургалтын байгууллагын багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай хангаж, үр дүнтэй хэрэгжүүлж, багш, эцэг эх, асран | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах | | |

## II. Сургуулийн өмнөх боловсролын бодлогын баримт бичгүүдийн судалгаа

*Хүснэгт 3. Сургуулийн өмнөх боловсролын бодлогын баримт бичгүүд дэх МХХТ-ийн талаарх судалгаа*

| № | Баримт бичгийн нэр | Батлагдсан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | **Хууль тогтоомж** | | | | |
| 1 | Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль | 2008 | Энэ хуулийн зорилт нь бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | - | - |
| | **Засгийн газрын тогтоол** | | | | |
| 1 | Сургалтын орчинд авах арга хэмжээний тухай | 2018.09.05 №276 | Сургууль, цэцэрлэгийн орчинд авах арга хэмжээг тусгажээ. | • Сургууль, цэцэрлэгийн орчинд хичээл, сургалтын үеэр сурагч, хүүхдүүдэд ухаалаг гар утас, түүнтэй адилтгах төхөөрөмж ашиглахыг 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хязгаарлах тухай<br>• Сурагч, хүүхдүүдэд ухаалаг утас, түүнтэй адилтгах төхөөрөмжийн хэрэглээг хязгаарлаж байгаатай холбоотойгоор гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран журам боловсруулж ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгүүдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | Сургалтын орчинд ухаалаг гар утас, түүнтэй адилтгах төхөөрөмж ашиглахыг хязгаарлах |
| | **Сайдын тушаал** | | | | |
| 1 | Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээ | 2020.08.06 А/17 | Коронавируст халдварын цар тахлаас хамаарсан онцгой нөхцөл байдалд өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн 2020-2021 оны хичээлийн жилийн сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад мөрдөх түр журам баталсан байна. | • Цэцэрлэгийн хүүхдэд зориулсан теле хичээлийг Монголын телевизүүдийн холбоотой хамтран бүрэн, чанартай бэлтгэх зохион байгуулах<br>• Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд зориулж теле хичээлийг үндэсний хэмжээнд зохион байгуулах | МХХТ-ийг ашиглаж буй зорилго:<br>• Сургалт зохион байгуулах |
| 2 | Цэцэрлэг, ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах | 2020.06.25 А/296 | Ердийн хэв шинж бүхий цэцэрлэг, ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид нэмэгдэл хөлс олгоход баримтална. | - | - |

| № | Баримт бичгийн нэр | Батлагдсан он, дугаар | Баримт бичгийн зорилго | Баримт бичигт МХХТ-ийн талаар тусгагдсан байдал | Дүгнэлт |
|---|---|---|---|---|---|
| | багшид нэмэгдэл хөлс олгох заавар | | | | |
| 3 | Хичээлийн жилийн бэлтгэл хангах талаар авах зарим арга хэмжээ | 2020.06.02 А/286 | Хичээлийн жилийн бэлтгэл хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, авах арга хэмжээг тусгасан байна. | Цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн суралцагчдад 2020 оны 9 сард зохион байгуулах бататгах хичээлүүдийн агуулга, арга зүйн зөвлөмж боловсруулах, хичээл, сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах платформ хөгжүүлэх дэд багийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулах | МХХТ-ийг ашиглаж буй зорилго:<br>• Цахим сургалт зохион байгуулах платформ хөгжүүлэх |
